





Сэтгэл гэгээрээсэй

М. Ариунт



М.ШАГДАРСҮРЭНГИЙН ОРЧУУЛГА



- **БУРХАН БАГШИЙН
АМЬДРАЛ**
- **ШАГЖАМУНИ
БУРХАНЫ ХӨРӨГ
ОРШВОЙ**

Улаанбаатар хот 2010 он

DDC
294.35
Ш-154

БУРХАН БАГШИЙН АМЬДРАЛ ШАГЖУМУНИ БУРХАНЫ ХӨРӨГ ОРШВОЙ

Орчуулагч:	М.Шагдарсүрэн Ш.Эрхэмтөгс
Хятад эхтэй тулгаж нягталсан:	Х.Цагаанхүү
Ерөнхий редактор:	До.Цэнджав
Редактор:	Чү.Энхболд
Хянасан:	Д.Тунгалаг
Дизайнер:	Д.Батцэнгэл
Хавтасны дизайн:	З.Даваажаргал
Хэвлэлийн хуудас:	28

АДМОН ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN 978-99962-0-256-8



ЕРӨНХИЙ РЕДАКТОРААС ӨГҮҮЛЭХИЙН УЧИР

Уншигч Таны өмнө гэгээрэл, оюуны хур шим оргилж буцалсан ном эрдмийн нэгэн гайхалтай ертөнцийг нээж байгаадаа өчүүхэн миний сэтгэл тун баяр хөөртэй байна. Энэ эрхмийг манай үеийнхэн одоо нэгэнт таньдаг, мэддэг, биширдэг болсон тул элдэв долоон үгийн нэмэр бараг илүүц ч гэлээ гол мөрний ус эргэж өөдөө урсдаггүйн учир, үеэс үед дамжсаар үнэ цэнээ алдахааргүй суварган их бүтээл туурвисны хувьд, хожмынхонд энэ нь шинэ үг болж улбаачлагдахын учир цөөнийг мөрлөв. Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор “элэгний” хэмээн ард олондоо нэр хүнд олсон мэс засалч, гарамгай дуун хөрвүүлэгч Маналжавын Шагдарсүрэн бага залуугаасаа ертөнцийн цаг хормыг ер бишээр хуваарилан, ном эрдэмд цэцгийн бал руу тэмүүлэх зөгий мэт шунаж, нэг хэлээс нөгөө рүү, нөгөөгөөс цаашаа гүнзгийрүүлэн суралцаж эдүгээ өрнийн болоод дорнын хэд хэдэн чухал гол хэл, хэлбичгийг ороо морийг уургалан барьж номхоруулахын анзаанд сурчээ. Бие сэтгэл мохож няцаж байсан ч хатамжлан, бэрхэд хүслэн гэгчийг бэхлэхийг түрүү болгосноор амьдралаа учир утгатай болгоод зогсоогүй, амжиж бүтээхийн туурвилзүйдээ асар

хурц гэрлийг асааж чадсан ховор билгүүн авъяаст, оюут гэгээнтэн эрхтгүй мөн.

Эрдэм чадал илт дорой буурай ч гэсэн эрхэм номун нөхрийн итгэж миний гарт бариулсан 20 боть сүмбэнг нэг бүрчилэн уншиж, илүү дутуу үг, арай дутмаг мөчид хальтирсан зүйл байна уу? хэмээн үг өгүүлбэрийг эрхийвчилэн торгоож хянамгайлахыг хичээсэн боловч нүдэнд өртөх, үзгийн үзүүрт баригдах зүйл тун багахаан тааралдав. М.Шагдарсүрэнгийн эл ботиудын хуудас бүрээс гэгээрэл, ариусахуй, танихуйн ертөнц тэр чигээрээ дэлгэгдэж оюуны ид хав амтагдаж, сэтгэлийг илбэдэн баясгаж байх юм.

Заримдаа “Амьдрал” гэдэг яасан ч хуурамчхан, хүн гэдэг ямар ч гүехэн, эрх мэдэл хөөцөлдөх гэдэг ямар ч мулгуу, алдар нэр гэдэг яасан ч хоосон юм бэ? дээ гэж шоолж инээмээр, гутармаар, бас баясмаар ер бусын саруул гүн ухаан гэрэлтэхийг уншигч Та мэдэрч намайг хүлцэн зөвшөөрөх бизээ. Ертөнц дахины буурал мэргэдийн эрт эдүгээгээс хураасан эрдмийн хамгийн шимтэй амттай, гэхдээ үгүйлэгдэн шохоорогдох, танин мэдэх, ухаарч гэгээрэх тэрхүү орон зай руу шурган орж, эрдэнэсийн эрдэнэсийг сонгож авна гэдэг бол хэр наад захын эрдэмт хүмүүн хөл алдаж, басчиг самгардан зарим заримдаа зориг мохож болохоор чөмөг дундрам ажил ажээ. Үүний тул М.Шагдарсүрэн яахын аргагүй өнөө цагийн гайхалтай соён гэгээрүүлэгч гэхэд оюут мэргэд энэхүү суварган бүтээлийн үр шимийг хүртсэний хойно хэн ч эргэлзэн гайхахааргүйг нотолно.

Нэрт орчуулагч М.Цэдэндоржийн “Орчуулагч хүн гэдэг бол зохиолчоос нь илүү хийх хэрэгтэй” гэж ам дүүрэн хэлсэн үг үлджээ. Үнэндээ Расул Гамзатовын

“Миний Дагестаныг” хөрвүүлсэн нь уг бүтээлээс хэтрүү давж гарсныг нэг бус бичгийн хүн үнэлж байхыг сонссон билээ. Шагдарсүрэн угийн аядуу даруу хичээнгүй нэгэн болохоор ингэж хэлж чадахгүй ч ингэж бодогдохоор бүтээдэгийг цухас тэмдэглэх нь зүй буйзаа.

Монголчууд, нэн ялангуяа эрдэмт лам хутагтууд бүр эртнээс буюу тавдугаар зууны орчмоос согд, уйгар хэлээс орчуулан хөрвүүлэх эш онол, эрдмийг зохион бичих туурвихаасаа ч илүүтэйгээр эзэмшсэн байх юм. Тэр бүү хэл орчуулгын онолыг боловсруулаад үүнийг дуун ухааны хөрвүүлгэнд “хууль” мэт сахиж баримтална гээд өдүгээгийн бидний хэлэх дуртай зарчимыг гаргаад тавьчихжээ. Үүнийгээ “Мэргэд гарахын орон” гэж нэрийдэж “Ганжуур”, “Данжуурыг” хөрвүүлэхдээ бичгийн сайдууд хулсан бийр хазайлгалгүй, худал хуудамгайг илчлэн, эндүүрэл илүүг элдэв ташаалгүй барьж байсан домог шиг яриа уламжлагдан үлджээ. Зөрчвөөс хулсан бийрийн үзүүрт хуудам явдал, худал олтгой зүйл байх учиргүйг мэдрүүлж зэгсэн баалчихдаг, оволзсоныг мохоон олбогт нь сөхрүүлдэг, мохоо сулбууг ирмэглэж хурцалдаг, олон ном судартай харьцуулан нийцүүлэх чанга дэг жаягтай байсан нь номун жудаг, цэдэг гэдэг ямархан ариун дагшин байжив хэмээн гайхмаар, бас биширмээр.

Эл судар бичигт “Урнаар найруулах”, “сайтар тохиолдуулах “утгын найрыг дагах”, “яруу найр зохисоор шүлэглэх” гэсэн гоц баримтлах түлхүүр үгс цөөнгүй тааралдана. Мөн гүн ухааны баталсан сөхөөсөн үгсийг “хурц бөгөөд мэдэхүйеэ амар үгсээр” орчуулах гэхчилэн сургаалжээ. Эртний судар номун хөрвүүлгэндээ М.Шагдарсүрэн “Мэргэд гарахын орон”, Дандины “Зохист аялгууны” зарчим сургаалыг даган баясаж монгол хэлнийхээ ухахуйяа гүн гүнзгий, сонсохуйяа эерүү уянгалаг,

танихуйяа олон утгат цэц мэргэн, бясалгахуйяа бурхан шидлэг, нээхүйеэ ер бусыг ёстой л чихүнү чимэг болсон гайхамшигт илэрхийллийг мөр бүрнээ гэрэлтүүлж чадсан байна. Үгийн гэрэлд судрын хуудас сүлэгдэж харагддаг бус уу. Тэр аливааг эх хэлнээ буулгахдаа ер зөөлөн зүдэх зүйлгүйг үл сонгон аль л болох адармаатай хэцүү бэрх, утга гишүүн далдалсан энгүй бэрхийг зориуд барьдаг нь харваач цэцэд сумаа тавихдаа цэцгийн шилбэ таслалгүй онохын агаар нэгэн ажээ. Ийм уран чадвар, билэгт үгийн чанад чадварыг шингээн ариун дээд адис ерөөлт “Бурхан багшийн сургаалийг” хэрхэн орчуулснаас олж цөхөх юмгүй. Үгийг чимэглэн өнгөлж чаддаг, бүдгийг дүрэлзүүлэн асааж чаддаг, хэт хурцыг будунгуйд орхиж бүдгэрүүлж мэддэг, хэт чахарганыг эгшиглүүлэн уясаж, хахирган хатууг яргуйн дэлбээ мэт булбарай ахуйд шингээж чадсан бичиг бийрийн эрдэмт хөвүүний эзэмшвээс зохих лавтай наадын таван эрдэм ухаан тэгширч бүрэлдсэнийг мэдэрч бахадлаа.

Олон жилийн туршид бичиг цаас нухаж одоо ч учрыг олохгүй манан буданд төөрөлдөж яваа манийн хувьд өөртөө нээсэн. “Үгэнд хөлийн таширгүй, үгэнд мэлмийн ташир буй, үгэнд тэргүүн ташир буй. Эл гурван ташрыг нэгэн үзүүрт нийтгэвээс бийрийн торгон үзүүрээс ухааны сувдан эрдэнэс алтан эрвээхэй шиг нисэлдэн унамой” гэсэн үгийн маань эзэн болох хүнтэй өнөөдөр учрав. Тэр гэнэн бядгүйн ухаан илааршиж, элдвийг үзэж эрхбиш буй болоод буй биш зүйлийг нэвт эргэцүүлэхтэйгээ болсон ид исгэлэн цоцмог үедээ барьж авсан “Бурхан багшийн сургаал” хэмээх гайхамшигт ботиос мэргэн уншигч Та ихийг олж, энэ эрхмийн номун билгүүнд найр тавин даган баясах бизээ. Хатуу бэрх үгийн мэлмийг зүйтэй нээвээс мянган бурхадгийгүүлэн баясах нь тодорхой. Үг энгийнээс энгийн болоод гүнзгийгээс гүнзгий тусмаа сэтгэлд төдөх

юмгүй буудгийн жишээг энэхүү сургаалийн хуудас бүрээс хүртэн мэдэрч болно. “Сургаал сонсолгүй зуун жил амьдарснаас сургаалийг мэдэж нэгэн өдөр амьдарсан нь дээр. Хүн өөрийгөө жинхэнэ ёсоор хайрлаж чадвал хорт нүглээс хамгаалж чадна. Хүн амьдрах хугацаандаа ядаж нэг удаа ч гэсэн залуу, идэр, ахимаг насны алинд боловч итгэл үйлдэх хэрэгтэй. Энэ ертөнц бол шунал, уур, мунхагийн галаар мөнхөд шатаж байна. Хүн энэ аюулаас аль болох хурдан зайлсхийх хэрэгтэй. Энэ ертөнц бол аалзны тор шиг хөөс хир дүүрэн тортой адил байна” гэх буюу өөрөөр бас “Цэвэр ариун бадамлянхуа цэцэг намгийн шавраас ургадаг шиг ертөнцийн хүслийн буртагаас Бурханы ариун Гэгээрэл үүсдэг” гэхчилэн юутай гэрэлт бурханлаг ид шидийн бадаг мөрүүд жасаалан оршсоныг тааж ядах юун билээ. Яаж бүхнийг тоочих...

“Японы хайку”-г баргийн мэргэд лавтай гүнзгий барин ядан явсаар Шагдарсүрэнгийн гар дээр иржээ. Гэхдээ Б.Явуухулан, Ж.Лхагва нар орос хэлнээс дамжуулан мэргэн ончтой орчуулсныг үнэлэх нь зүй. Харин Шагдарсүрэн шууд эх хэл дээр нь буюу японы жинхэнэ эхийг барьж авснаараа “монгол хайкучуудын” дотор тун дээгүүр олбогийг засаад авав бололтой. Манай “Ертөнцийн гурав” дэндүү гайхамшигтай боловч бүх талаараа хайкутай зэрэгцүүлэн дүйцүүлэхийн аргагүй өөр л дөө. “Ертөнцийн гуравт” холбоо хэлхээ учир шалтгаалцлын орон зайд маргаж мэтгэлцэхийн завдал өгөхгүй тасхийгтэл тархины орой руугартал хэлдэг. Дорнын мэргэд “Гуравтын гүн ухааныг” хүн төрөлхтний оюун ухааны далайд нэгэн гол мөрөн болгон урсган шингээж чадсан, гагц үүгээр бахархахад л үлэмжхэн зүйлийг сануулж чадна. Японы хайку үнэндээ мань мэтэд заримдаа юу ч биш юм шиг ухаж торгоход алинаар нь ч буумаар

санагддаг. Ийм тусмаа хайкуны гайхамшиг оршдог байна. Үүнийг үгээр буулгахаасаа илүүтэй гүн ухаан, далд дам ухааныг төлгөчилөн буулгана гэдэг орон орны дуун хөрвүүлэгч хэний ч аавын хүүгийн чөмгийг дундалсаар иржээ. Хайку шүлгийн санаа бол хушганы яс доторхи үрт идээ мэт үзэгдэж харагдахгүй нуугдмал зүйл шүү дээ. Түүнийг зургаа дахь мэдрэхүй буюу илбэ жилбийн гэмээр мэдрэхүйгээр илчлэн гаргана уугэхээс энгийн ухаанаар бол оньсыг тайлахын аргагүй бэрх зүйл юм.

Хортой загаснаас хордоогүй би

Хонгор бүсгүйн аалинд

Хордсон шиг хордлоо

...Гадаа бороо орсоор л...

Хөрш маань гэрлээ асаахад

Манайх бас гэрэлтэй болов...

...Тэртээ уулын цэцгэн дор

Хичнээн хүн нойрсож буйг

Хэн мэдэх ажаам...

Оргүй хоосонд би одоод

Отгоргүй тэнгэрээс унжих

Сакура болох байхаа...

Японоороо ямар байгааг мэдэхгүй, монголоор бол үг болоод утга санаа нь толины хэлтэрхийд буусан шумуулын дүрс шиг тод томруун өнгө өнгөөрөө дурайтал буужээ.

Японы хайку, эртний Персийн рубай, Энэтхэг хиндийн гүн ухаант эгшиглэл уужим Дармапада, Хятадын сонгодог яруу дуурсалт шүлгүүд, Төвдийн сүншигт гүн шүлэглэл, Буриад түмний сургаалт ариун бадаглал зэргийг орчуулсан нь дорнын их яруу найраг, оюун сэтгэлгээний “газрын зураглалд” хөл тавиагүй газар үгүй мэт байна.

Дэмий үгийг хэлж дэвэргэхийн тулд биш юмаа, дэнслэн байж дэн дун хагасыг хэлтэлж байгаа минь энэ юм шүү, эрхэм уншигчид минь, эрх биш та нар маань эдгээр ботиудыг уншаад харин тэр нөхөр чухал далдыг нээгээгүй байна” гэж зэмлэж магад.

Түүний орчуулсан Омар Хаямын рубайг уншихад бүдэг бүхэн гэрэлтэж, далд бүхэн ил гарч, утгагүй юмс утгатай болж, утгатай юмс утгагүй болж би ерөөс өөрөө хаанаа байгаагаа ч сэхээрэхээ хэсэг болив. Өчүүхэн мань мэт нь хэний төлөө, юун төлөө явав гэж санааширч, амьдралын туршид хөгийн гэмээр ёс зүй, жудаг, журам сахиусыг баримтлан шүтэж даруу буурай явсандаа гундасхийж ёстой нөгөө дураараа цалгилагч Омарын үг тархи сэтгэлийг мансууруулах шиг болсон нь чухамдаа орчуулагчийн үгийн урлагийн ид шид юм. Манай өмнөө барьдаг сайхан найрагчид, орчуулагчид Омар Хаямын рубайг жар далаад оноос л цухалзуулж эхэлсэн. Б.Явуухулан, М.Цэдэндорж, Х.Цэвээн, Л.Дашням, Д.Цоодол гээд аваргачуул өөр өөрийн ертөнцөөр тольдож рубайг буулгажээ. Эд оюуны мэлмийд юутай гэрэл гэгээ болсныг тэмдэглэх нь зүй. Омар Хаям гэдэг бол арван том орчуулагч нийлээд ч барахааргүй, цаана нь өдий төдийгөөр нь үлдэх аварга том ертөнц юм. Орчуулга гэдэг нэгэн бүтээлийг хэчнээн ч талаас нь ч нээж болох боломжтой байдгаараа өвөрмөц содон эрдэм юм.

Харин Шагдарсүрэнгийн орчуулга бол арабын эртний амьдрал үгийн утгазүйн өнгийг олж харсан. Тэр найрагчийн зан араншинг олж харсан. Хэт жимбийрдэх биш, зарим газар зөнгөөрөө туйлын хайнга юм шиг сулсхийгээд гаргачихсныг тэр хэвээр нь буулгасан. Өвгөн Хаян зориуд ингэж адармаалахаа мэдэлгүй яхав. Бурханы өмнөөс ч элдвийг сөргүүлдэг хүн

шүү дээ. Зохиогчоо эхлээд танина гэдэг орчуулагчийн уран нүд юм. Тэрхүү араб, перс, лалын ертөнцийн будангуй болоод өнгө гэрэлгүй ч юм шиг, солонго мэт өнгө гэрэлтэй болоод зэрэглээ мэт хуурамч ч юм шиг амьдрал ахуй нь харагдмаар, урт буурал сахалтай, битүү ороолтон чалма малгайтай өвгөн найрагчийн өвөр дээрх гоо бүсгүйн судасны цохилт мэдрэгдэж, амьсгалах нь ч, аальгүйтэх нь, тас тас инээлдэх нь ч сонстох шиг хөрвүүлэн буй лалын бийрэн оройт сүм, хавь орчин сонин ховор сэтгэлгээг хам цуг зурж чаджээ.

Хүн намайг архичин гэвэл, үнэндээ яг тийм

Хүний мөсгүй үймүүлэгч гэвэл, үнэндээ яг тийм

Би бол би, юу хүссэнээрээ, дураараа чалчицгаа

Би Хаямаараа л үлдэнэ, үнэндээ яг тийм. Билэг танхай, биедээ ааг омог тээнэ гэж энэ бизээ.

Бас нэгэн боть болж орсон Буриадын их гэгээнтэн Эрдэни Хайбзун Галшиевийн “Мэлмий нээхүйн мянган бадаг” ном бол эрдэнийн “Субашид” шиг цулаараа алт ажээ. Хэлэх ёстойг хэлчихсэн, ойлгоогүйг ойн тойнд оруулчихсан үнэхээр л ширээн дээрээ байлгаж өдөр бүр ядаж нэг бадгийг тогтоон уншиж бодож бясалгаад байвал ертөнцийн бүх явдал гарын алган дээр буух шиг болно. Энэ бол бас л дуун хөрвүүлэгчийн ид шид. Энэ бүхнийг яаж тоочиж барахав.

Өрнө, дорно ерөөс эх дэлхийн сод ухааныг нэгэн ай савд шингээн багтаана гэдэг хэд хэдэн хүн нийлж хийгээд барахааргүй зүйлийг амжуулсанд М.Шагдарсүрэнгийн хамаг гайхамшиг оршино. Хурд, самбаа гэдэг бол түүний хувьд зүрхний лугшилт шиг амсхийдэггүй агшин гэсэн үг юм билээ. Хятадын сонгодог найрагч Дү-Фүгийн “Сарны дор ганцаараа сархад хүртэхүй” шүлэгт,

Цэцэгсийн дундгүц дүүрэн архиа тавиад



Цэмцгийн зогсож ганцаараа хүртэхүй дор
 Гэгээн сарандсэржим өргөн ёсорхож
 Гэрэл сүүдэр нийлээд гурвуулаа согтовоо. Үүнийг
 тайлах гэж оролдохын хэрэг юусан.

Ертөнцийн гоо сайхан, ер бусын шидэт билбүүрдлийн
 өмнө жирийн хүн байтугай бурхдын хүслэн сэтгэл гээч
 цангасан, цанхаалсан морьд лугаа адилхан юм бус уу?
 Зургадугаар Далай лам Цаянжамцын “Хайрын дуулал”
 боть шүлгийг уншиж байхад эрхтгүй ингэж төрнө. Түүний
 бичгийн бурханы яруу догдлолт зовлон гунигийн замаар
 бэдрэн явж шүлгийн хагасаас уншваас,

...Дорно уулын орой дээгүүр
 Мөнгөн саран шагайгаад
 Дотно охины гэрэлт царай
 Миний сэтгэлд ургаад байнам
 Өнгөрсөн оны нялх нахиа
 Өнөө жил цоор болов
 Өнгөтэй залуу нас өнгөрөхөд
 Өмнө зүгийн нумнаас илүү бөхийв
 Золоор учирсан анхилам үнэрт амраг минь
 Зоргоороо явсаар чамаасаа хагацвал
 Цагаан гэрэлт оюун эрдэнийг олоод
 Цалгих давалгаанд оргүй алдсан мэт...

...Эмнэг адуу ууланд хулживч

Цалам бугуйлаар барьж болно.

Зангаа эвдэж хэрүүлч болсон амраг минь

Засарч номхролгүй бурханд ч дийлдэхээ болино...

..Тэр бүсгүй эхээс төрөөгүй

Тоорын модноос ургасан гэж үү?

Эр хүнээс уйдаx сэтгэл нь

Тоорын цэцэг унахаас хурдан юм...

Хөгшин шар банхар минь

Хүнээс дутуугүй ухаант амьтан минь

Үдшээр оргоод явдагийг минь

Үүрээр буцаад ирдэгийг минь дурсаарай...

...Бэхээр бичсэн мянган үгийг

Бороон дусал төдийхнөөр ч арилгаж болно

Сэтгэлийн гүн дэх бичигдээгүй санааг

Хэчнээн хүслээ ч арилгаж эс чадна. Жинхэнэ яруу эгшиглэнгийн охийг бусдаас түрүүлэн амсаж, түүнээ бусдад хүртээхээр оюун бодлыг чилээж, олдсон биеэ оломгүй ихээр зовоож, ороо хурц, яруу үгс эгшгийг бийр бэхний үзүүрт торгоон бэхлэж, билэг номун хуудсанд үлдээнэ гэдэг энэ мөнөөсөө мөн дөө.

Энэхүү 20 боть тус бүрдээ өөрийн онцлогтой, өөрийн шидэт ертөнцтэй. Ертөнцийн тайлагдашгүй оюун ухаан, сэтгэлгээ, гүн ухаан, яруусахуйн ухаан, аж байдал гээд гайхамшигт бүхэн, ховор чухаг эрдэнэсээс охь нь ёроолдоо тунгаагдан үлджээ. Зөвхөн “Монголын эзэнт гүрний арми” гэдэгт л их эзэн хаан Чингис хаан болоод түүний эрэлхэг жанждын сэтгэхүй, цэргээ удирддаг урлаг, хосгүй жанжны дүр төрх, монгол цэргийн тулааны нууц зэрэг нь аяндаа тодорч хүний санаанд оршгүй зүйлсийг гаргасан маш сонирхолтой содон төрх байдал, алдар цууг шимтэн уншиж мэдэж авна.

“Анагаах ухааны англи монгол толь”, “Анагаах ухааны монгол англи толь”, “Япон-англи-орос-монгол идэвхтэй үгсийн толь” “Монгол охь үгийн толь” “Ургамлын толь”, “Төвд монгол дөрвөн үндэсний толь”

“Төвд-монгол анагаах ухааны толь” бол оюуны мунхаг харанхуйг арилгагч мянган мэлмийг нээх мөнхийн зул гэдгийг харуулж чаджээ. Тоймгүй олон залуус түүний зузаан зузаан толь бичгийг эргүүлж чухам юунд хүрэхийг өнөөдөр тааж хэлэхэд хэцүү байна. Та юуны ч өмнө сөхөрч мэхийхгүй омголон бардам байж болноо. Гэвч агуу их эрдэмлиг оюун билэг, төгс гэгээрэл, ариусахуйн хутаг, мэргэн ухаан агуу их ном шастирын өмнө мэхийхээс аргагүй ээ. За ингээд яруу найраг, монголынхоо эх түүх, ёс заншил, билгэ зүй, гүн ухаан, шашин, анагаахуй ухаан, толь бичиг гээд номун бүхий л гоо сайхны үзэмжит тансаг цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлт ховор ертөнц таны өмнө хөшгөө нээхэд бэлэн боллоо.

Номун эрхэм садан М.Шагдарсүрэн маань элэг нэгтэн монголчууд, хүүхэд залуучуудад юу сурсан мэдсэнээ зориулах гэж яаж мэрийн мэтгэж зүтгэж байсныг хажуугаас нь харж, хар цай оочлон хамтдаа хэдэн сар, өдрийн шөнийн од анивчихыг үзэвээ. Оюуны хөдөлмөр гэдэг бол биеийн хөдөлмөрийн хажууд хэдэн мянга дахин хүнд нүсэр, хэцүү бэрх шүү дээ. Үүнийг үзэж туулсан хүмүүс л мэднэ, ойлгоно. Нүдэндилхэн арван давхар сүрлэг байшин нэгэн цагт ойчино. Харин оюуны гэрэлт бүтээл тэр бүр нүдэнд ил харагддаггүй. Жишээлэхэд, дээр дурдсан Омар Хаямын рубай хэдэн зууныг гайхшруулан туулж Араб ертөнцийн алдарт сүм харшаас илүү амьдарч, тэр танишгүй этгээд ертөнцийг дуурсгасаар байна.

“Ээ дээ алдав” гэж эргэн эргэн үзэж, эрдэмт номун мэргэдээс лавлан асууж, “Өвгөөн нэг шүүгээд өгөхгүй юу?” гэж далд утга томъёолол болгоныг зөв зүйтэй буулгах гэж их хотын гудамжинд нохой ч хуцахаа больсон түнэр харанхуй цагаар ширээний гэрэлтүүлэгчийн дор халимаг үсээ ч самначих завгүй сууж, нэг хэлээс эс

ойлгогдохыг нөгөө хэлээс олж шүүрдэн үзэхийн гэрчлэгч нь яах аргагүй би юмаа. “Хаявал яасан юм бэ? дээ” гэхэд “За байз хө, энд нэг хараадахъя. Тэр хаашаа бултав гэж...” хэмээн инээмсэглэн хэлээд түүнээ төдөлгүй олоод, “хүүхэдтэй болжээ” гэсэн үгийг анх сонссон эцэг шиг баярлана, хөөрнө. Ерөөс Шаагаа “Нэг хэлний ороо морийг нөгөө хэлний хулжсан мориор уургална” гэж ярих дуртай. Ийм учир Та бид ч азтай. Гэгээвчээр өглөөний тунгалаг эрүүл цэнгэг агаар орж ирэхийн адил оюуны хүчирхэг агаарыг нэгэн биед шингээхийн төлөө жинхэнэ эрдэмтэн хүн шиг, жинхэнэ урлахуйн инжаан дархан шиг, жинхэнэ соён гэгээрүүлэгч шиг зүтгэн зүтгэн, чармайн чармайн хөлс хүчээ цутган байж бүтээсэн (энэхүү) дүнжгэр, үнэнхүү бядлаг чанартай, үнэнхүү даацтай, үнэнхүү сод бүтээлүүд түүний оргилж буцалсан их мэдлэг авъяасаар тордогдон хэзээ ч баларч хуучрахгүй үеийн үед сүндэрлэн байх номын гэрэлт хөшөө дурсгал мөнөөсөө мөн.

Номын ариун цагаан буян дор мөргөмүй. Ном шастир, судрын бууршгүй их туяа Та нарын минь ариуссан сэтгэлийн гүнд гэрэлтсээр байх болтугай.

МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ,
МУИС-ИЙН ДОКТОР ПРОФЕССОР
ДОЛГОРЫН ЦЭНДЖАВ

2010. 04. 27, 28 Улаанбаатар

Story of Buddha by Hammalava Saddhatissa.



БУРХАН БАГШИЙН АМЬДРАЛ



ӨМНӨХ ҮГ

Энэ номонд та бидний сайн мэдэх нэгэн агуу хүмүүний амьдралыг өгүүлсэн болой. Энэ бол Энэтхэгт 2600 жилийн өмнө болсон үйл явдал ажээ. Номон дахь хаан,хан хүү,догшин дээрэмчин зэрэг олон зүйл үлгэрт гардаг үйл явдлыг санагдуулна. Гэвч энэ бол үлгэр биш юм. Та энэ номноос олж унших эрхэм хүмүүн бол үнэхээр энэ орчлонд төрөөд газар дэлхий дээр мөрөө гаргасан Будда Готама юм. Будда хэрхэн амьдрах тухай сургаж байлаа. Түүний сургаалиар өнөөг хүртэл Дэлхийн хүн амын тавны нэг нь замнаж байна. Энэ номонд эртний Энэтхэгийн зураачдын хэв маягаар зурагдсан 20 гаруй зураг, Бурханы амьдралын 12 тод үйл явдлыг дүрслэн харуулжээ. Номыг арван хоёр жил лам байж,бүх амьдралаа буддизмыг судлах,түгээн дэлгэрүүлэхэд зориулсан Шри Ланкийн эрдэмтэн Хамалава бичсэн юм. Хамалава 1990 оны хоёрдугаар сард Лондон хотноо таалал төгсчээ. Түүнийг мэддэг таньдаг хүн бүхэн тэрбээр бурханы жинхэнэ шавь ариун гэгээн хүн байсан гэдэгт итгэлтэй байдаг.





МАЯА ХАТНЫ ЗӨН БИЛЭГТ ЗҮҮД

2600 жилийн өмнө Хойд Энэтхэгийн Хималайн нурууны бэлд олон тооны жижиг хаант улсууд суурьшиж амьдардаг байжээ. Жижиг улс бүхнийг хаадууд захирдаг байв. Тэдгээр хаантулсын нэг нь Шагжийн улс байлаа. Тэр үед Шагжийн омгийнхоныг цэргийн гаралтай Судадаана хаанчилж байв. Улсын нийслэл нь Капилавасту (одоогийн Непал улстай хил залгаа) байлаа.

Нэгэн шөнө түүний хатан ер бусын сонин хачин зүүд зүүдэлж гэнэ. “Хушуундаа цэцгийн баглаатай том цагаан заан түүнд тайвнаар дөхөж ирээдхэвтрийг нь гурвантаа тойроод, яруу сайхнаар хүнгэнэн дуугарсан” хэмээн зүүдлэв.

Өглөө нь хаан өөрийн орны өнцөг булан бүрээс бүх мэргэдийг урин залж энэ зүүдний учрыг тайлахыг даалгалаа.

“Эрхэмсэг хаантан минь таны хатнаас агуу их сурвалжит хөвгүүн төрөх юм байна” хэмээн мэргэд айлтгалаа. Хаан хатан хоёр ихэд баярлав.

Хатан амаржихаа тэсэн ядан хүлээж, тэр үеийн заншлаар төрхөмдөө очиж амаржихыг хүсэхэд хаан даруй зөвшөөрч, аян замд ая тухтай морилохыг ерөөж, бараа бологчдын хамт замд үдэв.

БУДДА МЭНДЭЛСЭН НЬ





Гоё ганган хувцас, үнэт эрдэнийн зүйлсээр гангарсан бараа бологчдоо дагуулсаар хатан Маяа тансаг сайхан жуузанд морилж аян замд гарав. Зам нь ой дундуур зурайж Лумбини үзэсгэлэнт сайхан цэцэрлэг дундуур үргэлжилсээр.


Хатан энэхүү сэтгэл булаам үзэсгэлэнт газар Хималайн мөнх цаст оргилыг сүслэн биширч моддын сэрүүн сүүдэрт түр амсхийхээр саатав. Ийнхүү Лумбини үзэсгэлэнт цэцэрлэгт бодь модны мөчирт мутраа хүргэмэгц хатан амаржив. Энэ өдөр дүгэрэг сартай, хаврын таван сарын бэлэг дэмбэрэл бүрдсэн сайн өдөр байлаа. Модод цэцэглэж, зөөлөн сэвшээ салхи илбэж, шувууд уянгалан энэхүү дархан цаазат цэцэрлэг үнэнхүү жаргалтай ажгуу. Эрвээхэй, зөгий бал бурам цуглуулан цэцэгсээс цэцэг дамжин дүнгэнэн нисэж, байгаль дэлхий хан хөвүүнийг мэндэлсэндбаяр хүргэх мэт үзэсгэлэнтэй сайхан байв.

Аян замд одогсод Капилавастудаа эргэж ирлээ. Хүн зон хан хөвүүнийг үзээд асар их хөөрөн баясаж байв.

Хан хөвүүн нь жигтэйхэн хөөрхөн, арьс нь алтлаг, шүд нь лавайн өнгөтэй, үс нь хөхөвтөр хар туяатай үнэхээр өө сэвгүй үзэсгэлэнтэй төржээ.

ЗӨНЧ МЭРГЭНИЙ АЙЛДВАР

Хан хүүг мэндэлсний дараа ордныг зорьсон





анхны зочдын дотор агуу их мэргэн даяанч Асита байлаа. Тэрбээр хүүг үзээд баярлан инээснээ даруй гашуудан уйлав.

“Хүүд минь золгүй учрал тохиолдох нь уу” хэмээн хаан хатан хоёр сандран асуухад: “Танай хүүг агуу их амжилтууд дагалдан явах болно” хэмээгээд “Инээсний учир гэвэл хан хүүг үзсэндээ би аз жаргалтай байна. Учир нь тэр эгэл жирийн хүүхэд биш ер бусын агуутөрөлхтөн юм байна. Хожмоо тэр ялж төгс нөхцсөн, (төгс гэгээрсэн) бурхан болно гэж та нарт би зөгнөн хэлье. Уй гашууд (зовлонд) хэрхэн тайтгарах, жинхэнэ азжаргалыг яаж олж авахыг бүх дэлхийд тэр сургах болно. Би насан өндөр учир тэр сайхан өдрийг үзэж чадахгүй тул гашуудан уйлсны учир тэр” хэмээн өгүүлэв.

Хаан энэ үгэнд төдийлөн таатай байсангүй. Тэр өөрийн найман их мэргэнээ хан хүүд нэр хайрлахаар урин залав. Мэргэд хөвүүнийг үзэж түүний биед онцгой тэмдэг байгааг мэдлээ. Долоон эрдэмтэн хэлсэн нь: Хан хүү агуу их жанжин эсвэл эгнэшгүй их номлогч болно хэмээжээ. Найм дахь мэргэн Конданы бэрх болоод энгийн амьдралыг Бурхан болтлоо эдэлнэ хэмээн зөгнөв. Хаан хатан хоёр гэнэтийн уйтгарт автсан авч хүүдээ “хүсэл бүхэн биелсэн” гэсэн утгатай Сиддхарта гэдэг нэр хайрлажээ. Түүний овгийн нэр Готама юм.

Харамсалтай нь хан хүү төрөөд долоо хонож байтал үзэсгэлэн төгөлдөр Маяа хатан гэнэт таалал төгсөв. Хатны дүү Пражапата хан хүүг төрсөн хүү шигээ өсгөж хүмүүжүүлэв. Цаг хугацаа өнгөрөх тусам хөвгүүн үзэсгэлэнтэй, ухаалаг, хүчтэй, гайхамшигт сайхан эр болон өсч байлаа. Ааш зангийн хувьд өрөвч зөөлөн сэтгэлтэй хүмүүжил сайтай, хүн бүхэнд хайрлагдсан нэгэн байв.



ХҮҮХЭД БОЛОВЧ АВРАГЧ

Сиддхарта амьтанд маш хайртай байлаа. “Үеийнхэнтэйгээ тоглноос ганцаараа тоглосон нь дээр, тэд заримдаа харгис хэрцгий юм” гэж боддог байв.

Нэг удаа тэр үеэл ах Девадаттатай ойгоор зугаалж байтал нөгөөх нь дээгүүр нисэж явсан хунг харваж газарт унагав. Сиддхарта гүйж очоод сумыг нь эвтэйхэн сугалан авчээ. Дараа нь эмийн ургамал түүж цусыг нь тогтоохоор шарханд нь шүүсийг шахаж дусаав. Девадатта хүрч ирээд:

“Хунг надад өг, би түүнийг харвасан юм чинь” гэхэд,

“Чи түүнийг алсан бол тэр чинийх болох байлаа. Харин шархадсан байхад нь би эдгээсэн тул минийх байх ёстой” гэж хан хүү эсэргүүцэв.

Тэр хоёр маргалдсаар эцэстээ мэргэдийн шүүх дээр очиход:

- Шувууг алахаар завдсан нь бус аварсан нь авах ёстой гэж шийджээ. Сиддхарта хунг авлаа. Девадатта аймшигтай хорон санаатай байв.


Сиддхарта өрөвчхөн сэтгэлтэй, бясалган тунгаах дуртай болж өслөө. Үүнд эцэг нь багагүй санаа зовж байв. Хааны толгойд мэргэдийн урьдчилан сануулсан





үг үе үе орж, хүү нь хэзээ ч үнэний эрэлд хатахгүй, хааны ордны тансаг амьдралаас татгалзахгүй байхаар тийм орчныг бүрдүүлэхээр шийджээ.

Судадана хаан хүүгийн дэргэд өвчин зовлон, ядарсан зовсон, өвгөд эмгэд, амьдралын муу муухай болгоныг, бүр үхлийн тухай дурсахыг ч хатуу хориглосон байв.





ХАН ХҮҮ ГЭРЛЭСЭН НЬ

Хан хүү нас биед хүрч гэрлэх цаг боллоо. Хаан эцэг нь хөрш хаадад захидал илгээв. Элч нар хан хүү хэдийгээр баян, үзэсгэлэнтэй боловч цэргийн жанжин бус, бид аймхай хүнд гүнжээ өгөхгүй гэсэн хариуг авчирлаа. Судадана хаан сэтгэл нь зовж гаслав. Харин хан хүү би ямар ч тэмцээнд сурснаа үзүүлж ялж чадна, нум сум харвасан ч дийлнэ хэмээв.

Энэ өдөр газар сайгүй хөөр баясал болж, үнэт чимэглэлтэй жууз тэргүүд, гоё ганган хувцасласан морьтонгууд өөрийн онцлогтой туг далбаагаа хийсгэсээр хааны ордны өмнөх том талбайд цугларцгаав.

“Сиддхарта жолоодлогын уралдаанд түрүүлээ, Сиддхарта хан нум сум харвах тэмцээнд ялаа” хэмээн энд тэндгүй уухайлан байлаа. Үнэхээр хан хүү ямар ч тэмцээнд төвөггүй ялжээ. Ийнхүү өөрийн гайхамшигт авъяасаа цэргийн урлагт үзүүлснээр хаан, бэр сонгох их найрыг хийлээ. Хөрш хаадууд охид гүнж нараа дуртайяа илгээж байв.

Гайхалтай нь Сиддхарта хан үзэсгэлэнтэй гүнж Яшодхараг эхнэрээ болгон түмэн олноос шилж таалвай. Эцэг нь охиноо түүнд дуртайяа өгөн агуу тансаг шинэ ордонд тэд гал голомтоо асааж олныг баясуулан цэнгүүлж байлаа.

Хаан маш жижиг зүйлд ч санаа нь зовж байв.

Цагийн улирал улиралд зориулан гурван ордон урлан босгожээ. Нэгийг дулааны улиралд нөгөөг борооны, гуравдахийг хүйтэн цагт зориулан цогцлоожээ. Орднуудыг тойруулан усан оргилууртай үзэсгэлэнт цэцэрлэг, тунгалаг нууруудад нь ховор загас сэлэн, бадамлянхуа цэцэг дэлгэрч хос хунгууд хөвөн наадах ажгуу.




ДӨРВӨН ЗӨГНӨЛТ УЧРАЛ

Нэгэн удаа Сиддхарта ордны гадуур салхинд зугаалахыг хүсчээ. Цагаан морьд хөллөсөн гоёмсог жууз тэргэнд сууж хотын гудамжнаа гарав. Хотын иргэд хан хүүгээ баярлан угтлаа. Тэдний дунд нуруу нь бөгтийсөн нэг өвгөнийг гэнэт хан хүү олж үзэв. Тэр урд нь хэзээ ч ийм нүүр төрхтэй хүнийг үзэж байсангүй. Морин тэргээ зогсоож:

- Хүн шиг л юм, харин үс нь яагаад цагаан байдаг билээ. Хацар нь унжсан, арьс нь үрчгэр, яагаад шүдгүй юм бэ? хэмээн гайхан бие нь сулхан, бөгтийсөн, саваа мод тулаад явж байх юм. Энэ чинь юу юм бэ гэж асуухад энэ бол настай хүн, тэр олон жил амьдарчээ гэж Чандак хариулав. Тэр өвгөнийг үзээд хан хүү уйтгарлан гашуудав. Цаашаа явж байтал өвчтэй хүн тааралдав. Газраар мөлхсөн, бүх биеэр нь яр шарх болсон өвчнөөсөө болж орь дуутавин, амнаас нь цагаан хөөс цахарсан байв. Энэ бол өвчтэй хүн, бидний хэн ч гэсэн хэзээ нэгэн цагт өвдөж болох юм гэж зарц нь хариулав.


Гурав дахь удаа тэд салхинд гарахдаа оршуулгын ёслолтой тааралдав. Хүмүүс шарилыг үүрч уй гашуу болон явав. Яагаад энэ хүнийг дамнаад явж байгаа юм бэ? гэж Сиддхарта асуув. Чандак: - Хаантан минь.





Энэ бол нас барсан хүн. Ертөнцийн мөнх бусыг үзэх гэдэг яах ч аргагүй та болон таны үзэсгэлэнт хатан Яшодхарадч ялгаагүй хэзээ нэг өдөр энэ ертөнцийг орхих цаг магадирнэ хэмээн хааны хоригийг мартан айлтгаж орхив. Цаашдаа зугаалмааргүй байна. Одоо гэртээ буцъя гэж хан хүү хэллээ. Буцах замд бас нэг хачин хүн тааралдав. Үсээ хусуулсан мулзан толгойтой шар хувцастай хүн байв.

- Энэ бол зовлонг арилгах арга замыг эрэхээр гэр орноо орхисон хувраг хүн гэж зарц нь тайлбарлав. Тайван дөлгөөн байдал нь хан хүүг гүн бодолд живүүлвэй. Энэ дөрвөн үйл явдал Сиддхартын амьдралыг орвонгоор нь эргүүллээ.





ГЭРЭЭСЭЭ ЯВСАН НЬ

Эцгийн бүхий л болгоомжлол, оролдлого нь Сиддхартад дэмий хоосон үр дүнгүй зүйл болов. Хаан эцэг маш их санаа зовж байлаа. Яшодхара хүү төрүүлсэнд хааны урам сэргэж том найр хийв. Одоо Сиддхарта эхнэр хүүхдээ орхихгүй байх гэж Судадана хаан найдаж байлаа.

Хан хүү найранд оролцож байсан боловч түүний сэтгэл санаа алс хол өөр газар байлаа. Би тэр шар хувцастай нүцгэн толгойтой амгалан дүртэй, хувраг хүн шиг болох хэрэгтэй юм байна гэж бодож байв. Өнөөдөр л энэ амьдралаас явна. Энэ он жилүүдэд би ихээхэн хоосон өнгөрүүлжээ.

Тэр шөнө Сиддхарта унтлагын өргөөнөөс өлмий дээрээ сэм сэмхэн гишгэлэн гараад Чандакд өөрийн хайртай морийг эмээллэхийг хүсэв. Дараа нь унтлагын өрөөнд амарч байсан Яшодхараг зөөлөн өрөвдөнгүй харахад эхнэр нь хүүхдээ цээжиндээ тэврээд бөх бат нойрсож байв.

“Би зовлонгийн шалтгааныг тайлаад(олж мэдээд) та нар дээрээ эргэж ирнэ. Та нарыгаа өвчин зовлон, үхэл, хагацал, өглөх хөгширөхөөс чөлөөлөхийн тулд юм шүү” гэж бодов.

Энэ үедтэр дөнгөж 29 настай байв. Түүнд хичнээн хүнд байсан ч шийдвэрээ өөрчилсөнгүй. Тэр морио

унан Чандактай хамт ордны хаалгаар гарч давхилаа.

Ниранзана голд хүрээд хан хүүгийн хувцас, чимэглэлээ тайлаад урт үсээ илдээр хяргаж бараа бологчдоо өгөөд ордон руу буц хэмээв. Хайрт морио зарцдаа өгөв. Зарц нь түүнийг бишгүй ятган хичнээн гуйвч нэмэр болсонгүй. Чандак ордондоо буцаж очоод: “Хан хүү эрснээ олоод буцаж ирнэ. Уйтгарлаж гуних хэрэггүй” гэдгийг дамжуулах хэрэгтэй байлаа.



АМЬД ХҮЧ

Сиддхарта ханы хувцсаа даяанчийн ноорог навтаргаар солиод цааш ганцаар явав. Тэр орон гэргүй даяанчилж үнэний эрэлч болов.


Тэр эхлээд Алар Клонтай, дараа нь Удрактай уулзав. (Тэр үеийн алдарт багш нар) Сиддхарта маш их хичээл зүтгэлтэй суралцав.

Эцэст нь Алар хэлсэн нь:

- “Надад чамд сургах юм одоо алга, чи надтай тэнцүү боллоо. Эсвэл чи үлдээд миний шавь нарыг сургах юм уу” гэв.

Сиддхарта “Та намайг өвдөх, өглөх, үхэхээс яаж чөлөөлөгдөхийг сургаж чадах уу” гэв. Алар: “Үгүй ээ чадахгүй, үүнийг хэн ч мэдэхгүй” гэв. Дахиад багшийн эрлээ үргэлжлүүлэв. Гэвч олсонгүй. Дахин ганцаараа болов.

Дараа нь таван даяанчтай танилцаж нөхөрлөв. Тэднийг Каундиня, Бахадрчка, Вашла, Маханама, Асбажид гэдэг байлаа. Хамтдаа урт хугацааны бясалгалаар хичээллэж сэтгэлээ төвлөрүүлдэг байв. Эгэл хоол амралтаас татгалзаж, хаа ч хамаагүй газар өвс шороон дээр унтаж, маш хэцүү хүнд байлаа. Гэвч тэд сэтгэлээ ариусгахын тулд биеэ зовоох хэрэгтэй гэдэгт итгэж байлаа.





Даяанч хан хүү өлсөж ядарснаас болж ухаан алдаж хөсөр унан үхтэлээ сульджээ. Түүнийг нэг малчин олж аваад тэнхэртэл нь бага багаар аманд нь сүү дусааж тордож сэхээжээ.





СУЖАТЫН БЭЛЭГ

Хан хүү ийм аршийн амьдралын утгагүй болохыг ухамсарлаж мэдэрлээ. Үүнээс өмнө тансаг амьдрал гэдэг бас юу ч биш гэдгийг ухаарсан байлаа. Тэр энэ хоёр туйлшралын дундаж замыг сонгохоор шийджээ. Тэр дахиад энгийн амьдралаар амьдарч эхэллээ. Таван даяанч цөхрөн түүнийг хаяж одов.

Хан хүү үнэнийг багш үгүй, нөхөдүгүй ганцаараа эрэхээр шийдлээ. Тэр үед хөрш тосгонд Сужата гэдэг эмэгтэй амьдран суудаг байжээ. Жижигхэн хүүтэй. Өөрт оногдсон сахилаа гүйцэтгэж Сужата цагаан будааг сүүнд тусгай аргаар чанаад, бясалгал хийж буй газар руу очоод, амгалан суух тэр хүнд дөхөж сөгдөөд:

- Эрхэмсэг ноёнтон минь та бурхан ч бай, хүн ч бай сүүнд чанасан будааг минь хүлээн авч зооглоно уу. Таны хүссэн зорилго тань биелэх болтугай гэвээ.

Хан хүү өргөлийг хүлээн авлаа. Тэр голд биеэ угаагаадэрэг дээр гарч хооллолоо. Дараа нь голын эрэг дээр ирж хоосон аягаа “Хэрэв би гэгээрэх хувьтай бол энэ аяга голын урсгалыг сөрөөд дээш урсаг” гэж шивнээдусандтавив. Аяга нь урсгал сөрөн одвой.



ШИЙДВЭРЛЭХ ЯЛАЛТ


Өөрийн хүчиндээ хязгааргүй итгэлтэйгээр сүглэгэр бодь модны дэргэд эргэж ирээд дахин бясалгаж эхлээд “Төгс гэгээртлээ би энэ газраас дахин хөндийрөхгүй” гэж тангараглав. Өдөржин, шөнөжин бясалгаж байв.

Шулмын санаатнууд хүссэн зорилгоос нь холдуулахыг эрмэлзэж байлаа. Хайрт эхнэр хүүхэд нь, ордон дахь тансаг амьдрал, төрөл төрөгсөд, найз нөхөд, инээд баясал, найр цэнгэл нүдний нь өмнүүр жирэлзэн өнгөрч аль нь ч түүнийг суудлаас нь хөдөлгөж чадсангүй. Итгэл төгс шийдсэн Готама бясалгалаа үргэлжлүүлсээр байлаа.

Ухаан сэтгэл нь ариусаж, гэгээрэв. Эцэст нь тэр төгс гэгээрч жинхэнэ ялж төгссөн бурхан болов. Зургаан жил хайсан эрэл төгслөө.

Энэ бол дүгрэг саран орчноо мөнгөлөг өнгөөр гийгүүлсэн Вайшакха сард боллоо. Будда яг 35 нас хүрчээ. Хожим анхны бясалгал хийсэн модыг Гэгээрлийн Бодь мод гэж нэрлэх болов.

Энд Бодигаяа гэх жижиг хотүүссэн болно. Бодь модны доор Будда зургаан долоо хоног өнгөрөөв. Бурхан тэр модыг гэгээрснийхээ төлөө долоон долоо хоног нүд салгалгүй талархан ширтэв гэж домогт өгүүлдэг.





ҮНЭНИЙ ХҮРДИЙГ ЭРГҮҮЛЭВ

Долоо дахь долоо хоногийн эцсээр Будда өөрийн нээсэн номын сургаалаа айлдахаар шийдэв. Тэр номыг ухаарах нь амаргүй энгийн хүн ойлгох нь хэцүү гэдгийг мэдэж байлаа. Гэвч тэр сургаалыг хэн хүлээж авахад бэлэн байгаа түүнд хүртээх нь өөрийн үүрэг гэж үзжээ.

Сиддхартагийн багш нар нь аль хэдийнээ таалал төгссөн байв. Тэр үед тэр өөрийг нь хаяад явсан таван даяанчийг саналаа. Тэр замдаа гарч олон мянган бээр явган аялж Исидитани, Ланей ойд хүрч ирэв. Таван даяанч урьдын адил нөгөө хүнд хэцүү дасгалаа хийсээр л байв.

Тэд Сиддхартаг холоос хараад таниагүй боловч ойртоод ирэхэд бүр өөрчлөгдснийг нь мэдэрчээ. Байгаа дүр төрх нь агуу гэгээн, сэтгэлийн их ариун хүч дотроос нь гэрэлтэж байхыг харлаа. Даяанчид түүнд босож гүн хүндэтгэн ёслоод сууж саатахыг уриад заншлаараа хөлөө угаах ус барив. Тэр орой хагас сартай билэгт сайн өдөр байв.

Бурхан анхны сургаалаа лам нараа, хуваргуудаа хэмээн тэдэнд хандаад: Даяанч хүн хоёр туйлшралаас зайлсхийх хэрэгтэй. Зөвхөн миний ойлгож мэдэж замнасан дундаж зам л гэгээрэлд хүрэх жинхэнэ мэдлэг үнэнийг хайрласан юм гэв.

ЗОВЛОН



Ёс суртахуун:

Зөв үг

Зөв үйл

Зөв амьдрал

Сэтгэл:

Зөв чармайлт

Зөв дурдтгал

Зөв бясалгал

Ухаан:

Зөв үзэл

Зөв эрмэлзэл



БУДДИЗМЫН ҮНДЭС

Дараа нь Будда таван даяанчид сургаалын үндэс болсон дөрвөн үнэнийг айлдсан.

1. Ертөнцөд зовлон байгаа нь үнэн (төрөх, өвдөх, өтлөх, үхэх. Хайртай хүн, эд юмнаасаа хагацах, байхгүй юмыг хүсэх)
2. Зовлонгийн шалтгаан байгаа нь үнэн (Хүсэл, шунал. Түүний язгуур үндэс нь биеэ тоох, хувиа хичээх, бид хичнээн их хүснэ, төдий чинээ амьдралдаа үл ханана)
3. Зовлон гэтлэх нь үнэн (Зовлонгоос ангижрахын тулд хүсэл шуналыг тэвчих хэрэгтэй. Түлээ мод шатаж дуусахад түүдэг гал унтардагийн адил хүсэл шуналыг таягдан хаяхад зовлон зүдгүүр төгсөнө.)
4. Зовлон гэтлэх арга зам буй нь үнэн (Хүсэл шуналыг таягдан хаях зам бол дундаж үзэл)

Өөрөөр хэлбэл найман мөрт зам юм.

- Зөв үзэл
- Зөв эрмэлзэл
- Зөв үг
- Зөв үйл
- Зөв амьдрал
- Зөв чармайлт
- Зөв дуртгал
- Зөв бясалгал

Таван даяанч сэтгэл санааны хувьд хүчирхэг тэнхээтэй хүмүүс байлаа. Тэд сургаалыг сайтар ухаж Буддагийн анхны шавь нар болов. Ингээд анх хуваргуудын чуулган (Сангха) үүсэв.





КИСГОТАМИ

Амьдралын багш Буддагийн алдар даян дэлхийд тархав. Нийгмийн янзбүрийн давхаргаас түүний шавь болохоор хүмүүс ирж байлаа. Хаад,бярманууд,ядуус ялгаагүй сэтгэлийн түшиг тулгуурыг олж байв. Тоо томшгүй олон хүн түүнээс зөвлөгөө авч тайвшрах ажгуу. Ийм хүмүүсийн нэг бол Кисготами юм.

Түүний анхны хүүхэд нь нас барж туйлын уй гашууд автсан байлаа. Хүүгийнхээ шарилыг тэврээд эргэж амьдруулах эм тан хайж газар сайгүй тэнэжээ. Нэгэн сайхан сэтгэлт хүн таарч түүнийг Будда дээр авчрав.

Түүнд золгүй явдал тохиолдсоныг Будда сайтар ойлгож байлаа. Будда эмэгтэйг гичний үр цуглуулж ирэхийг хүслээ. Энэ бол бүхний мэддэг үр,түүнийг олоход ямар ч үнэ орохгүй гэхэд түүнд итгэл төрлөө. Гэхдээ ганцхан болзол бий.

Гичний үрийг хэн ч хэзээ ч үхэж байгаагүй тийм гэр бүлээс цуглуулж ирэх хэрэгтэй гэв. Кисготами айл бүхнээс газар сайгүй сурсан ч үхэл хагацал үзээгүй айл гэж байхгүй байлаа. Саяхан миний нөхөр, эцэг,эх,эгч нас барсан гэгцгээнэ.

Хотын бүх айлаар орж үзэхэд үхэл тохиолдоогүй нэг ч гэр бүлийг Кисготами олсонгүй. Буддад буцаж ирээдагууих багш үхэл хэнийг ч тойрдоггүй гэдгийг

ойлгуулах гэсэн юм байж гэдгийг олж мэдлээ. Уй гашуунамайг сохолжээ хэмээн Буддад хэлжээ. Одоо түүний сургаалыг хүлээн авахад бэлэн боллоо.

“Хэзээ нэгэн цагт үүссэн бүх юм, ирээдүйд үүсэх юм зайлшгүй эвдэрч задрах бөгөөд оршин тогтнохоо болино. Бүх дэлхий дээр юуч мөнх бус гэсэн ганцхан хууль байдаг юм” гэдгийг ухаарууллаа.




ШАГЖА ОМГИЙН МЭРГЭН ОЛОН ТҮМЭНД ТУСЛАВ

Нэгэн удаа Будда Савадха хотын ойролцоо Жетавана сүмд олон хуваргуудтай хамт ном айлдаж байв. Тэнд нэгэн хүнд өвчтэй лам бүх бие нь яр шарханд идэгдсэн, дотор эвгүй оргимоор байсан тул ихэнх нь түүнээс холдон зайлахыг бодож байлаа. Зовлонгоосоо болж хөөрхийлөлтэй хаягдсан энэ хувраг хэний ч тусламж үгүй тарчилж байв.

Будда өөрийн шавь Анандтай түүнийг эргэхээр очиж “За бие чинь яаж байна даа. Хэн нэгэн чамайг эргэж тойрч байна уу” хэмээн Буддаг асуухад: Миний бие маш муу байна. Хэн ч намайг эргээгүй, би хэнд ч хэрэггүй болсон гэжээ. Будда Анандыг даруй уух юм, даавуу хэрэглэл авчир гэв.

Анандыг ирмэгц түүнийг хамтдаа угааж, цэвэрлэж, хучлагыг нь сольж өгч хэвтүүлэв. Дараа нь Будда бүгдэд нь: Хуваргуудаа та нар бие биеийнхээ төлөө санаа зовох ёстой. Тусламж шаардлагатай болсон нэгэндээ туслахаар ирж байх хэрэгтэй. Сонсоцгоо. Сайтар тогтооцгоо. Хэрэв хэн нэгэн надад туслая, үйлчлэе гэж хүсэж байгаа бол өвчтэй зовлонтой хүнд туславал илүү буянтай болно шүү хэмээжээ.

Буддагийн агуу их нинжин сэтгэл ийм байлаа.





Түүний золгүй нэгэнд зориулсан тэр агуу их нинжин сэтгэл түүний залгамжлагчдад өнөөдрийн өдрийг хүртэл үлгэр жишээ болж ирлээ. Бурханы бүх сургаалыг мэргэн ухаан, нинжин сэтгэл гэсэн хоёр агуу их эхлэлтэй хэмээн үздэг.





АНГУЛИМАЛА

Акимсака хөвүүн сайхан сэтгэлтэй, дуулгавартай, сэргэлэн ухаалаг өсжээ. Тэрбээр Такшашилад суралцахаар очиж, атаархмаар сайн суралцаж олон шагнагдав. Зарим нь аргаа барахдаа багшдаа худал гүтгэлэг хов мэдүүлжээ. Багш нь тэр цууүг, гүтгэлгэнд үнэмшин аймшигтайгаар уурлаж “Чи ингэж сурсныхаа төлөө надад төлбөр төлөх ёстой. Төлбөр чинь мянган хүний эрхий хурууг тасдаж авчирвал цайрна” гэлээ. Акимсака хичнээн гуйсан ч багш нь өөрийнхөөрөө зүтгэсээр байв.

Тэгээд Акимсака дээрэмчин болохоос аргагүй болж ойдирэн хажуугаар өнгөрөх аянчдыг дайран барьж авч хурууг нь тайрч байлаа. Хуруунуудаа олсоор хэлхэж зүүлт мэт хүзүүндээ зүүж байв. Түүнийг Ангулимала гэж дуудах болсон нь хуруун сондорт дээрэмчин гэсэн утгатай ажээ. Хааны цагдаа нар ч түүнийг барьж чадсангүй, цаг хугацаа өнгөрсөөр байлаа. Түүнд ганц хуруу тасдах дутуу байв. Гэтэл төрсөн эх нь хажуугаар нь өнгөрөхийг хараад эх рүүгээ дайрахаар шийдэв. Тэр багшийнхаа өрийг төлж тооцоо дуусгах хэрэгтэй байлаа. Энэ агшинд тэр дэргэдээ нэг лам ирснийг анзаарав. Ангулимала эхээ орхиж лам руу дайрлаа. Тэр нь Будда дүрээрээ байв. Ангулимала хичнээн хурдлавч түүнийг гүйцэж чадсангүй. Хөөе хуваргаа зогсоочээ гэж хашгирсанд:

“Би аль хэдийнэ зогсоод л байгаа шүү, харин чи зогсох хэрэгтэй байна” гэж Будда хариулав. Хүн хар хурдаараа гүйж байхад зогсож байна гэж яриад байдаг. Дээрэмчин үүнийг яаж ойлгох билээ. Будда би бүх гэм алдаагаа арилгасан юм. Ийм учир дахин төрөхгүй, зогсож байгаа юм. Харин чи өөрийгөө бохирдуулж бузарлаж байгаа учир дахин дахин төрж муутөрөл аван, зовох болно гэжээ. Ангулимала багшийн үгийг ухаарч түүний хөлд сөгдөн хувраг болж гэгээний зэрэгт хүрэв.




БУДДА ДАЙНЫ АЮУЛЫГ ЗАЙЛУУЛАВ

Рохини гол Шагж, Колиев гэдэг хоёр алдарт хаант улсыг заагладаг. Гурван жил дараалан ган гачиг болж, голын ус татарч байв. Шагжийн тариаланчид өндөр далан барьж, голын усыг бүгдийг өөрийн талбай руугаа урсгахаар шийджээ. Колиевын хүмүүс үүнд нь эгдүүцэж усыг хувааж ашиглахыг шаардснаас олны уур хилэн, хэрүүл тэмцэл нь дайн болж хувирав. Нэгэн өглөө хоёр талын цэргүүд голын эрэг дээр ирж тулалдав.

Будда цус ихээр асгарахаас сэргийлж тэр газар ирэхэд түүнээс цацарч байгаа хайр энэрлийн гэрэл нь цэргүүдийн зүрхэнд дүрэлзэн ассан галыг унтраав. Тэд хуяг дуулга, зэр зэвсгээ хөсөр хаяв. Юунаас болж дайн гарахад хүрснийг Будда асуухад:

- Уснаас боллоо, аль аль тал нь талбайгаа услах хэрэгтэй байлаа гэв. Тэгэхэд Будда хаадаас асуусан нь:
- Хаадаа сайн санаат хүмүүсийн болон хүний амьдрал үнэтэй юу? эсвэл Рохини голын ус үнэтэй юу? аль нь вэ? надад хэлээд өгнө үү, гэв.
- Мэдээж хүний амьдрал шүү дээ эрхэм ээ





гэхэд, тэгвэл бие биесээ хорлон сүйтгэж дайтаж байхын оронд сайн санааны үүднээс зориг гаргаж биесээ ойлгосон бол мэргэн ухаалаг байх байжээ.

Дайн бол хамгийн аймшигт, эрүүл бус сэтгэхүйн уршиг билээ гэж айлдав. Тийнхүү Будда хүн эрүүл ухаанаар сэтгэвэл дайн тулаан төгсөх цаг ирнэ гэдгийг баталсан юм.





НАЛАГИРИЙН ЗААНЫГ НОМХОТГОСОН НЬ

Буддагийн сургаал газар сайгүй түгэн дэлгэрэхэд маш олон тооны хүмүүс хувраг болж тэр дундаа хааны гэр бүлийхэн ч мөн адил хоцорсонгүй.

Тэдний нэг Буддагийн үеэл ах Деваддата байв. Тэрээр хүүхэд ахуй цагаасаа хамт тоглон өссөн ч атаархан хорсч, ямар нэг аргаар түүнийг хөнөөж, лам нарын чуулганыг өөрөө толгойлохыг мөрөөдөж байлаа.

Нэгэн удаа Буддаг ном бясалгаж байхад Деваддата нүсэр том хад өнхрүүлсэн боловч тэр нь хясаа мөргөж хоёр хуваагдан Буддагийн хоёр талаар бөмбөрч оджээ.

Бас нэгэн удаа Налагирийн зааныг согтоож Буддагийн өөдөөс тавьжээ. Ухаангүй согтуу заан галзуу мэт урагш давшлав. Эрхэм Ананд багшийгаа аварч өөрийгөө золиослохоор шийдэв. Гэвч Бурханы биеэс хайрын их гэрэл цацарч галзуу зааны хилэнг дарлаа. Агуу хүчит зэрлэг араатан номхорч, их багшийн өлмийд сөгдөв. Будда зааны магнайг илж энхрийлээд, лам нартай хамт сүмдээ буцаж мориллоо.





ТӨРӨЛХ ХОТ КАПИЛАВАСТУД

Буддаг Ражагар хотдоо заларч буйг мэдээдтүүний төрөлх хот Капилавастугаас хаан эцэг Судадаана элч илгээн: Би насан өндөр боллоо. Үхэхээсээ өмнө хүүтэйгээ уулзмаар байна гэж хэлүүлэв.

Тэгээд Будда шавь нартайгаа Капилавастудаа ирлээ. Төрсөн гэрээсээ гараадудсан хан хүүгээ харах гэж ард олон хуран цугларав. Ордонд түүнийг хаан эцэг нь болоодхааны гэр бүлийн бусад гишүүдугтлаа. Будда тэдэнд зориулж ном айлдахад сургаалын үнэн зөвд бүгд гүн итгэцгээв.

Харин Будда маргааш өглөө нь айлаас айлдочиж бадар гуйхад хаан эцэг нь:

- Хүү минь, чи ордондоо хооллохгүй юунд эцгийнхээ нэр төрийг гутааж гуйлга гуйж байгаа юм бэ хэмээн ихэд гомдов.
- Бадар барих нь бидний ёс заншил юм шүү дээ хэмээн Буддаг тайлбарлахад хаан эцэг бүр ч уурсан
- “Заншил гэнэ шүү. Чи бол гуйлгачин биш, хан хүү!” гэж халаглав. Будда эцгийгээ тайвшруулахыг оролдож
- “Хаан эцэг минь ээ! Та бол хаан язгууртай, би бол Буддагийн язгууртай.

Тэгэхээр би зөвхөн энгийн хүмүүс юу өгснийг нь л идэж хүртэх учиртай юм” хэмээн хичнээн хэлээд ч нэмэр болсонгүй эцэстнь эцгийн сэтгэлийг хүндэтгэн бууж өгч ордондоо цай зоог барьж байхаар болов.

Энэ хугацаандуулзаж амжаагүй байсан Яшодхара хатан дээр очиход тэрээр Буддаг хармагц гүйн ирж хөлд нь сөгдөн мэгшин уйлж гарлаа.

Будда түүнийг аргадан тайвшруулав.



БУДДАГИЙН ҮНДСЭН БАЯЛАГ

Яшодхара хатан Капилавастуд Буддаг заларч ирсний дараахи долоо дахь өдөр түүний хүү долоон настай Рахулыг эцэгт нь золгуулахаар авчирч:

- “Хүү минь хар даа. Энэ алтаар туяаран гийж байгаа эрхэм гэгээнтэн бол чиний эцэг. Тэр маш их баян байсан. Түүнд очоод өв хөрөнгөө уламжлахыг хүсээрэй” гэв. Рахула эхийн хэлсэн ёсоор эцэгтээ сөгдөн мөргөв. Будда:

“Хүүд миний өв хөрөнгө хэрэгтэй. Хөрөнгө мөнгө, үнэт эдлэл, орд харш, сүйх тэрэг, зэр зэвсэг цөм бий. Гэвч би түүнд гэгээрэлд хүрэх тэр замыг зааж бэлэг барьяа” хэмээн бодож өөрийн анхны шавь Шарибудрад Рахулыг хувраг болгохыг даалгав.

Судадана хаан үүнийг мэдмэгц Буддад: “Чамайг гэрээсээ оргож явсны дараа би маш их зовж байсан, тэгээд өөрийн бүхий л хайр энэрлээ Рахулд зориулсан. Харин одоо чи түүнийг надаас авч явж болохгүй” гэв.

Будда хаан эцгийгээ тайвшруулж төгс үнэнийг ойлгуулснаар эцэг нь түүний сургаалыг хүлээн зөвшөөрч, хааны гэр бүлийн олон гишүүд хувраг болцгоов.






АГУУ ИХ ТАЙВШРАЛ

Төгс гэгээрлийг олоход 35 настай байжээ. Түүнээс хойш хаа ч явсан түүнийг үзэх гэж, түүний сургаалыг сонсох гэж хүмүүс газар сайгүй цуглардаг байв. Тэрбээр Будда хэмээн хүндлэгдэх болов. Бүтэн 45 жилийн турш шавь нартайгаа хойдболон зүүн Энэтхэгээр аялан ном айлдаж байв. Хаад, баян худалдаачид, лам нарын чуулганд өгөөмөр гараа сунгаж цэцэрлэг сүм олныг бариулж тэнд нь Будда шавь нартайгаа амьдардаг байлаа.

Бурханы сургаалд амьдралыг энгийн тайван, хүмүүст тус болж үйлчлэхээр зориулахыг сургасан байдаг. Хуврагуудад зөвхөн идэх хоол, өмсөх хувцас, хоргодох орон, эм тан байхаас бус, их хөрөнгө зoorь, тансаг орд харш зохихгүй гэж үздэг. Буддагийн сургаалыг дагаж байгаа хүн бүхэн хувиа хичээгч бус, хомхой ховдог, шунал, тачаал, хорон санаа, эндүүрэл, төөрөгдлөөс чөлөөлөгдсөн байх ёстой.

Будда өндөр насалж жанч халав. Кусинагара хотоос холгүй өвдөж Сала цэцэрлэгийн модны дор хэвтэж, хүрээлэн буй шавь нартаа: “Юм бүхэн мөнх бус. Шударга, сонор сэрэмжтэй, хичээнгүй нямбай, мэрийлттэй байгтун. Бүтээж бүрэлдсэн бүхэн задарч сарнидаг, хичээл зүтгэл гаргаж гэгээрэлд хүрэхийг хичээгтүн” хэмээв. Энэ бол Буддагийн сүүлчийн сургаал байлаа.






- * Будда 80 насандаа таалал төгсөв. Тэр дахин төрөхгүй ч үхэхгүй боллоо. Ватакха дүгрэг сартай шөнө үдшийн бүрий нөмөрч, амьтан бүхэн амрах цагт Буддагийн цогцсыг ёслол төгөлдөр чандарлаж, Бурханы шашныг дээдэлдэг олон оронд хүртээж, одоог хүртэл нандигнан хадгалж шүтэн биширч байна. Бурхан багшийг таалал төгссөний дараа сүм хийд нь сургалтын төв болж байлаа. Бурханы сургаал, Шриланка, Балба, Түвд, Хятад, Солонгос, Япон, Вьетнам, Камбож, Тайланд, Бирм, Монгол зэрэг Азийн орнуудад өргөн тархжээ. Өнөөдөр энэ шашныг 500 сая хүн шүтэж байна. Буддагийн шашинтай бүх орнуудын соёлын хөгжил нь үндсэндээ түүний сургаалын ачаар хөгжиж байна. Энэ хөгжил бол ямар ч зэвсэггүй, дайнгүй дусал ч цус асгаруулахгүй байх тийм сургаалыг номлож чадсан ажгуу.
- Сургаал нь энэрэн нигцүлсэнгүйн ачаар дэлгэрчээ.

释迦牟尼佛画传




ШАГЖАМУНИ БУРХАНЫ
ХӨРӨГ ОРШВОЙ



1. Буддын сургаалыг үндэслэгч Шагжамуны овгийн нэр Гуатама, өөрийн нэр Сиддарта (Сэдэд Радна) болно. Тэрбээр манай он тооллын өмнөх зургаан зуун хорин дөрвөн онд одоогийн Балба улсын Лумбиний цэцэрлэгт төржээ. Түүний эцэг бол эртний Энэтхэгийн Шагжийн улсын хаан Судадана, эх нь хатан Маяа нар болно.



2. Хаан, хатан хоёр гэрлээд олон жил болсны дараа сая Маяа хатан бие шалтгаантай болов. Эртний Энэтхэгийн уламжлалт заншлаар хатан төрхөмдөө очиж амаржих ёстой байлаа. Иймд хаан бараа бологч нарын хамт хатныг түүний төрсөн хот Девадарситад үдэж мордуулжээ.



3. Капилавасту, Девадарсит хотын хил заагт Лүмбиний цэцэрлэг оршмуй. Зам гудас өнгөрч явахдаа хатан, саглагар ногоон модны дор тухлан амрах зуур хан хөвгүүнийг төрүүлжээ.



4. Энэ өдөр тавдугаар сарын тэргэл саран цэлмэг тэнгэрт гийсэн, цэцэрлэгт зөөлөн сэвшээ салхи намуухан салхилсан, цэцэгс дэлгэрч анхилуун тансаг үнэр түгээсэн, шувууд жиргэх нь хөгжмийн уянгат эгшиглэн цуурайтах мэт, хүмүүний ертөнц тэр аяараа баясан цэнгэж, бяцхан хан хүү төрснийг тунхаглан баясах мэт тун таатай, нэн аятай байлаа.



5. Энэ үест газар доргиж, хурмастаас хоёр мөнгөн гол мэтнэг нь бүлээн, нөгөө нь хүйтэн рашаан цуган буувай. Энэхүү рашаанаар хан хүүд угаалга үйлджээ.



6. Хаан эцэг Судадана хан хүүг зөвхөн өөрийн жижиг улсыг бус нийт Энэтхэгийг нэгтгэн захирсан, хорвоод нэр алдар нь түгсэн Чакравартин мэргэн цэцэн удам дамжсан, хаан болоосой хэмээн хүсч мөрөөдөж байлаа.




7. Капилавасту хотын ойролцоо аглаг ууланд олон даяанч, хувилгаан нар амьдран суудаг юмсанж. Тэдний дундхамгийн мэргэн цэцэн эрдэмт бярман бол өндөр настай Асита байлаа. Тэрбээр хан хүү мэндэлсэн баярт мэдээг зөнгөөрөө мэдээд төлөг буулгахаар хааны ордонд морилон ирэв.



8. Өвгөн хувилгаан хан хүүд аз жаргалыг ерөөгөөд, төлөг буулгасны дараа гэнэтхэн уйлахад Судадана хаан гайхаж, юуны учир уйлсаныг гайхшран асуужээ.




9. Мэргэн өвгөн бярман: Хан хүү агуу их хүний бүрэн шинжийг төгс агуулжээ. Хэрэв хожмын ирээдүйд бясалгал үйлдэж, гэгээрвээс бурханы хутгыг олох, хэрэв хаан суурийг залгамжилваас тэнгэрийн доорх улс гүрнийг захирсан их хаан болох юм байна. Гэвч миний насан өндөр болсон тул хан хүү бурханы хутгыг олох тэр мөчийг үзэж эс чадах учраас ийн харамсан уйлав гэжээ.



10. Мэргэн бярманы үгийг сонсоод хаанд баяр гуниг зэрэгцэв. Гуниг төрсөний учир бол хан хүү өсч эрийн цээнд хүрээд хааны орыг үл залгамжилж, гэрээс дайжин даяанчийн амьдралд биеэ зориулчих буйзаа гэсэн эмзэг бодол байлаа.

Хаан чин сэтгэлийн хүслээ эрхэмлэн яланд өршөөл үзүүлж, ядууст хишиг хүртээж, брахман нарт өглөг өргөв. Улс гүрэн дээр доргүй бүжиг наадам, баяр цэнгэлээр бялхлаа.



11. Хан хүү төрсний тав дахь өдөр хаан Судадана бүх шадар сайд, эрдэмтэн мэргэдээ ордондоо цуглуулж хан хүүд ямар нэр хайрлах тухай хэлэлцээд Сэдэдраднаа буюу “Хүсэл бүхэн биелэсэн” гэдэг нэр хайрлахаар тогтов.



12. Хан хүү мэндлээд долоо хоноод байхад Маяа хатан гэнэт таалал төгсөв. Энэ нь хаан болон албат иргэдэд маш гүн харуусал уйтгар гуниг авчирчээ.



13. Маяа хатныг таалал төгссөний сүүлд Судадана хаан хатны дүү Пражапатыг бага хатнаа болгоод хан хүүг асран өсгөх итгэл хүлээлгэв. Тэр бүсгүй хожим нь Энэтхэгийн Буддын шашны анхны гэлэнмаа (Бикшүү) нарын нэгэн болсон түүхтэй.



14. Хан хүүг долоон нас хүрэхэд хаан эцэг нь нэрт эрдэмтэн мэргэдийг урин залж, тэр үеийн Энэтхэгийн хамгийн оргил гүн ухаан, таван эрдэм, дөрвөн ведад хүүг суралцуулж эхлэв. Хан хүү төрөлхийн сэргэлэн ухаалаг тул нэгийг сонсож арвыг мэдсээр арван хоёр насандаа эрдэм ухаандгүн нэвтэрч төгс боловсров.



15. Хаан хүү төрөлхийн өрөвч, зөөлөн уян сэтгэлтэй учир амьтныг хайрлан энэрч, гэмтээж алахаас нэн их цээрлэдэг байлаа.

Хүмүүс түүний энэхүү байдлыг үл ойлгон “Хулчгар хан хүү” гэж хочлон шоолдог байв. Хаан эцэг нь сонсоод ихэд сэтгэл эмзэглэн, санаа зовдог байлаа.



16. Нэгэн өдөр хан хүү цэцэрлэгээр зугаалан явах зуур шавжаар хооллож байгаа шувууг хараад ихэд гайхаж, шавжийг өрөвдөн, юунд амьтад эв найртай оршиж чадахгүй, бие биеэ, хүчтэй нь хүчгүйгээ хөнөөнө вэ? хэмээн гуниглан бодов.



17. Хаан Дроноданы хан хүү Девадатта түүнтэй нас чацуу бөгөөд үеэл дүү нь юм. Мөн өдөр Девадаттаг нисч яваа галууг харван унагахыг хан хүү олж харав.



18. Хан хүү хармагц гүйн очиж шархадсан зэрлэг галууг тэврэн авч “Хүмүүс нигүүлсэх сэтгэлгүйгээс жижиг амьтныг ч хөнөөж байна. Би чиний шархыг эдгээгээд онгон байгальд чинь буцааж явуулна” хэмээн шивнэв.



19. Яг энэ үед Девадатта олзоо авахаар ирэхэд “Энэ жижиг амьтныг дураар бүү алагтун” хэмээн гуйсандтүүний гуйлтыг үл тоомсорлон Сэдэдраднааг хулчгар хэмээн доромжлов.




20. Тийнхүү тэдний маргаан зогсолгүй, Судадаана хааны өмнө шүүлгэхээр иржээ. Хаан Девадаттыг тайвшрахыг хүсээд “Чи харваж намнахдаа гойд мэргэн авьяастай тул дахин зэрлэг галуу намнаж чадахгүй гэж санаа зовох явдалгүй, өөр галуу намна” гэлээ.



21. Энэ үг хан хүүгийн урмыг хугаллаа. Хаан эцэг Девадаттын амьтны амь хороогоод, хэрцгий байгааг ягаад зэмлэхгүй харин урамшуулж байгаагийн учрыг ойлгосонгүй. Хан хүү үүнийг хүний хувиа хичээгч аминч үзэл хэмээн дүгнэжээ.




22. Хэдэн өдрийн дараа галууны шарх эдгэрч дахин нисч чаддаг болов. Хан хүү галууг цэцэрлэгт сул тавихад хаан хүү рүү харж хоёр дахин ганганаад дуртай дургүй нисэн одов. Хаан хүүгийн сэтгэл ихэд догдлон хоцров.



23. Хан хүү, Девадатта хоёрын маргааны дараа “хулчгар хан хүү” гэдэг нэр ордны гадуур тарсан боловч тэр үүнийг нэг их тоосонгүй. Девадатта ихэд онгирч цэргийн эрдэмд гаргууд хичээллэж байв. Тэрээр бүх Энэтхэгийг зэвсгийн хүчээр нэгтгэх зорилготой байлаа. Үүнийг Судадана хаан ихээхэн таашааж байв.




24. Нэг өдөр хаан хүүгээ дагуулж түүний хулчгар занг өөрчлөх зорилгоор анд гарахад хан хүү аргагүйн эрхэнд дагаж явав. Гэнэт тэнгэр муухайрч тэдтөөрч бараа бологчдоосоо салцгаав. Удаан явсны дараа тэнгэр алгуур харанхуйлж эхлэв.




25

25. Судадана хаан зэрлэг амьтны сүргийн дунд байгаагаа мэдэв. Эцэг хүү хоёр зэвсэг агссан боловч ялна гэдэг найдваргүй байв. Хүүгийн хулчгар занг бодон, эцгийн хайраар хүүгээ тэврэн яаралтай үед хэрэг болуужин хэмээн нум сумаа бэлэн барьж байлаа.




26. Гэнэтнэг том заан тэднийг чиглэн гарч ирэв. Тэр аварга зэрлэг амьтан тал тал тийшээ харан ухасхийн довтолж байгааг нь харахад маш аймшигтай байв.

Хаан Судаана хүүгээ тэвэрчихсэн хамгаалалтад бэлдэж байлаа. Гайхалтай нь аварга заан хаан, хүү хоёр руу чиглэн ирээд ямар нэг дайрч довтолох шинжгүй амгалан тайван зогсов.




27. Хаан тайвшрав. Гэнэт хан хүү эцгийнхээ гараас мултраад аварга заан руу гүйж очив. Хаан сандран араас нь “Аюултай шүү”



28

28. Хан хүү зааны нуруун дээр үсэрч гараад хад чулуумэтбатбэх суучихав. Түүний энэ эрэлхэг, зүрх зоригтой байдал нь “аймхай хулчгар хан хүү” гэдгийг бүрмөсөн хийсгэлээ. Хааны хамаг биеийн хүйтэн хөлс асгарч, сэрэхэд энэ бүхэн хар дарсан зүүд байлаа.



29. Хаан Асита даяанчыг урин авчирч зүүдээ тайлахыг хүсэв. Асита: Том цагаан заан бол эв эеийн бэлэгдэл. Ирээдүйдхан хүү ертөнцийг аврах зорилгоор, ар гэрийн амьдралыг орхиж бясалгал үйлдсээр ертөнцийн агуу их Гэгээн болох юм байна гэв.




30. Хан хүү дэлхийг эзлэхийн тулд цэргийн хүчээр өрсөлдөхгүй, харин цоо шинэ сургаалыг үүсгэн нийт ард түмний энх амгалан сайн сайхны тусын тулд олон түмнийг хэтэрхий мэргэн ухаанаар жолоодно. Тэр гэгээрсний дараа бурхан болно гэжээ.



31. Даяанчийн өгүүлэхийг сонссон хааны сэтгэл хөдөлж урам орж, түүний хэлж буй нь учир шалтгаантай үнэн юм гэж итгэж байлаа. Гэвч Судадана хаан: “Заавал хуварагын амьдралыг туулж, бясалгал үйлдэхгүйгээр, цэргийн эрдэмд төгс боловсорвоос хүн зонд азжаргалыг авчирч чадна” гэж урьдын адил тээнэгэлзсээр байлаа.



32. Ингээд эзэн хаан цэргийн эрдмийн алдарт жанжнуудыг урьж хан хүүд цэргийн эрдэм заахыг даалгажээ.



33. Хан хүү маш авхаалжтай байж, аливаа эрдэмд гойд гавшгай суралцаж байв. Тэрээр алдарт жанжнуудын сургаал дор өргөн мэдлэг, гайхамшигтай авъяасаа хөгжүүлж байлаа. Ялангуяа морин дээрээс харвалдах, цавчилдах, морьт тэрэг жолоодох зэргийг гарамгай эзэмшиж чадлаа.



34. Хан хүү эрийн цээнд хүрмэгц эзэн хаан түүнийг ганцаардмал амьдралаас нь салгаж эртхэн гэрлүүлэхийн тулд сүйт бүсгүйн эрэлд гарчээ.



35. Зэргэлдээ орны Колияа хотын Супрабудда хааны том охин Яшодхара гүнж маш үзэсгэлэнтэй, ухаантай, буянтай ажгуу. Хаан Судаана бэр гуйсанд хаан Супрабудда шууд хариу хэлэх хэцүү байна, гүнжийг хан хүүдөгөх тухай хэлэлцэхээр сайд түшмэдээ цуглуулж хурал чуулган зохиоё гэв.

Хол ойрд үзэсгэлэн гоо, эрдэм ухаанаараа алдаршсан гүнжээ чухам аль хан хүүд хатан болгон өгөхөө шийдэж чадалгүй Супрабудда хаан түшмэд, сайд нараа цуглуулан зөвлөлдлөө.



36. Хуралдаж зөвлөлдсөний эцэст, аварга зааныг хатуу дарсаар согтоогоод сул тавьж, түүнийг номхруулж чадсан хүнд гүнжийг өгье гэсэн зарлиг гаргалаа. Зааныг номхроох тэмцээнд ураг барилдах хүсэлтэй хан хөвгүүд бүгд оролцох ёстой болжээ.




37. Супрабудда хааны энэ зарлиг нийт төв Энэтхэгийг доргиож, язгууртны хөвгүүдийн гижгийг хүргэж, энэ тэмцээний ялагч болохын төлөө алганыхаа загатнааг гаргахаар бэлтгэл хийж эхлэв.

Ялангуяа Девадатта цэргийн эрдэмдгарамгай тул ялна хэмээн бардамнаж байв.




38. Тэмцээний өдөр талбай үзэгчдээр пиг дүүрэв. Хан хүү Сэдэдраднаа, Девадатта хоёр ч иржээ. Хүмүүс хэн ялж гүнжийн сүйт залуунь болох тухай марган, мөрийцөж байв.




39. Говлосон цаг болмогц согтуу зааныг төмөр торон хашаанаас гаргахад заан хошуугаа сүртэйгээр хаялан, их дуугаар урамдан, дэвхцэж байв.


Өөрсдийгөө чадалтай эрэмгийд тооцсон язгууртан хөвгүүд тэмцээний талбарт үсрэн орж ирсэн боловч өөрийн эрхгүй галзуурсан мэт согтуу зааны хэмжээлшгүй хүчинд автан тулааны талбарыг орхин зугтаж байлаа.




40. Энэ үед нэг хүчтэй зоригтой залуу эр согтуу зааны дэргэд алгуурхан дөхөж очоод гэнэт хошуун дээрээс нь барьж аваад гуд татаж унагав. Тэгээд талбай дээгүүр чирч гулдарч гарлаа.



41. Тэр зоригт эр яллаа хэмээн итгэж маш их баяр хөөртэй байх тэр мөчидгэнэт Девадатта тэр зоригтэр рүү үсрэн очиж зааныг унагаж чирч хамаг хүчээ барсан түүнийг хумиж аваад арав гаруй тохой хол чулуудаж орхив. Тэр зоригт эр ганц ч үг ган хийж амжилгүй газар дээрээ таалал төгсөв.



42. Амьтан үймж байх үеэр Сэдэдраднаа талбайд аажуухан алхалсаар орж ирэв. Хан хүү шархадсан согтуу зааныг зөөлөн илэхэд хүмүүс гайхаж алмайрав. Хан хүүгийн биеийн эргэн тойрноос түмэн туяа цацруулсан, алтан гэрэл тусаж зааны биеийг гийгүүлэв. Согтуу заан нэгэнтээ уртаар амьсгал авч нүдээ нээж, алгуурхан өндийн босч ирлээ.



43. Согтуу заан аль хэдийнээс ижилдэн дассан мэт хан хөвгүүний өмнө ирж маш номхон хүлцэнгүйгээр зогссон нь хааны зүүдэнд үзэгдсэн тэрхүү зураг амилах шиг болов. Хан хүү зааны нуруун дээр гарч суугаад, цугларсан олон руу аажмаар дөхөх үест Сэдэдраднаа хан хөвгүүн түм насалтугай хэмээн хурайлж байлаа.



44. Энэ гайхамшигт ялалтын дараа Яшодхара гүнж хан хүүгийн сүйт бүсгүй болж, хөөрч догдолсон ард олон ч үзэсгэлэнт хосод ерөөлийн дээдийг дэвшүүлж байв.



45. Гэрлэсний дараа Яшодхарагийн гүн хайр, ялдам ааш хан хүүгийн сэтгэлийн гүнд хуримталсан хүнд бодлуудыг сарниулж чадсангүй. Тэрээр бүх амьтан адил эрх тэгш хэмээн үзэж Бярмануудын зиндаархах тогтолцооны ёсны эсрэг хатуу зогсож байв.



46. Нэгэн өдөр хан хүү эцгээсээ нийслэл хотыг тойрон аялахыг хүссэнд хаан нэн даруй хөсөг, заан бэлтгэж өндөр зиндааны түшмэлүүдийг хан хөвгүүнд бараа болгон хамт явуулав.



47. Хан хүү бараа болочдынхоо хамт хэрмийн зүүн хаалгаар гарч байгалийн үлэмж сайханд сэтгэл сэргэж, хөгжилтэй явж байтал замд нь нэгэн бөгтөр нуруутай цал буурал үстэй, доод биеэ даавуугаар халхалсан өвгөн гарч ирэв. Тэрээр өрөвдмөөр, салхинд хийсчихмээр хатингар туранхай харагдаж байлаа.



48. Хан хүү заан дээрээс бугаад настан руу очоод түүнтэй зөөлөн эелдэг ярилцлаа. Тэр настан амандаа ганц ч шүдгүй, дүлий нэгэн байв. Тэр орь ганцаараа хоцорч хүүхдүүд нь түүнийг өргөж тэжээхээс зайлсхийж гэрээсээ хөөсөн ажээ.



49. Хан хүү сэтгэл нь маш зовж таныг асрая гэв. Настан: Би асруулахыг хүсэхгүй, миний залуу насыг эргүүлж өгөхийг мөнх урт наслуулахыг хүсье гэв. Настны үгийг сонсоод хан хүү ямар ч хариууг хэлж чадалгүй, ордон руугаа буцав.




50. Хэдэн өдрийн дараа хан хүү бараа бологчдын хамт хэрмийн баруун хаалгаар гарч аялав.


Хаан хан хүүгийн аялах замдөвчтэй гуйлгачин хүмүүсийг байлгаж болохгүй гэж урьдчилан тушаасан боловч, баруун хаалганаас холгүй замд үхэх гээд хэвтэж байгаа нэг өвчтэй хүн тааралджээ. Яс арьс болоод, гэдэс нь нуруутайгаа нийлсэн тэрээр үхлээ хүлээж гиншиж байв. Хан хүү бараа бологчоос энэ хүн яахаараа ийм болов оо? гэж асуусанд:



51. Чандака үнэнийг нуухыг зүрхэлсэнгүй: Энэ бол өвчтэй хүн, биеэ тордолгүй байснаас өвчин үүсдэг юм. Баян, ядуу, дээдэс, доодос ялгаагүй өвчинд нэрвэгдвэл зовлонтой учирдаг юм. Хаан хүү энэ үгийг сонсоод харамсангуйгаар сэтгэл тавгүйтэн ордондоо буцъя гэв.



52. Хан хүү ордондоо буцаж ирснээс хойш ямар ч баяр баясгалангүй уйтгарлан шаналах болов. Баян тансаг, юугаар ч гачигдаагүй хэрнээ гунигт бодлоос салж эс чадан, олон түмнийг яаж амар амгалан болгох вэ? гэж өөрөөсөө асууж байлаа.




53. Хүүгийн сэтгэл таагүй байгааг хаан мэдэж байсан боловч бага явдал гэж үл тоон, хан хүүг өөр нэг аялалд явахыг ятгав.

Хаан, эзэнт улсын нийт иргэдэд нүд, сэтгэлд зохимжгүй аливаа зүйлсийг хан хүүгийн явах зам дагуу байлгаж эс болох, зайлуулж цэвэрлэх зарлиг буулгаад Девадаттыг бараа болж явахыг тушаав. Түүний цэргийн эрдэм гарамгай эзэмшсэн байдал хан хүүг зоригжуулан хөгжөөх бизгэж хаан итгэж байлаа.



54. Тэд хос цагаан үхэр хөллөсөн тэргэн дээр морилж, хаан хүүгийн ард Девадатта сууж явав. Замын турш хүмүүс хан хүүд баяр хүргэж ерөөлийн үг дэвшүүлж байсанд Девадаттагийн атаархал хөдөлж байж суух газраа олж ядаж байв.



55. Нилээд явсны эцэст тэд зам хөндлөн гарч ирсэн оршуулах ёслолтой таарч, хан хүү тэргээ зогсоохыг тушаалаа. Цогцос дамжилсан эрчүүд гүн гашуудаж араас нь дагасан эмэгтэйчүүд, хүүхдүүд цурхиран уйлж, харсан хэн хүний элэг эмтрэм хэцүү байх ажээ.



56. Хан хүү: Одоо буцъя даа гэхэд Девадатта ихээр шоолон инээж: Та үхсэн хүнээс айдаг үнэхээр “Хулчгар хан хүү мөн юм аа” гэж даапаалав.



57. Хан хүү “Девадатта бусдыг үл тоон, элэглэж байх юм. Ертөнцөд мөнх байх хүн гэж үгүй, гагцхүү үхэл гэдэг эрт орой хэмээсэн цаг хугацааны ойлголт юм даа” гэж бодон, зам гудас тохиолдох байгалийн үзэмжийг үл хайхран ордондоо сэтгэл гонсгор эргэж ирэв.




58. Энэ бүх аялалд хаан хүү баяр хөөртэй мордож уйтгар гунигтай эргэж ирдэг байлаа. Хэдийгээр үзэсгэлэнт эхнэр Яшодхара, саяхан төрсөн хүү Рахул нар нь түүний дэргэд байх боловч хан хүү өөрийн гунигт бодлоос салж эс чадан бодлогшрон суудаг байв.




59. Элэн ядарсан настан, өвчин эмгэгт баригдсан ядуучууд, хорвоог орхин одох талийгаачид хаан хүүгийн ухаан бодлоос салж өгөхгүй байлаа.

Хүмүүний амьдрал гэдэг агаар дахь цэцэг, усанд туссан сар шиг хоосон юм гэж үү? гэсэн бодол хан хүүд ямагт төрдөг байлаа.



60. Судадаана хаан Хан хүүгийн сэтгэл санаа амар түвшин бус байгааг мэдээд, Аситагийн хэлсэн зөгнөл биелэж болох юм гэж болгоомжлон, сайд зөвлөхүүдээ дуудаад яаралтай нууц хуралдаан хийж, хан хүүд зориулан зуны ордон бариулж, дуу хуур, хөгжим бүжиг, найр цэнгэлээр таслахгүй байх зарлиг буулгажээ.



61. Нэг удаа хан хүү цэцэрлэг дэх цөөрөмд байгаа загаснууд, хоол булаацалдан бие биетэйгээ тэмцэж, том нь жижгээ, жижиг нь сам хорхой олж идэж байгааг ажиглаад энэ нь амьдрахын тулд хүчтэй нь хүчгүйгээ дарж байдаг жам юм. Хүн төрөлхтөн олз ашиг, нэр алдрын хойноос хөөцөлдөхдөө дайн дажин, үймээн самуун дэгдээж алаан хядаан, үхэл зовлон үүсгэж байдаг нь мөн үүнээс үүдэлтэй. Үүнийг хэрхэн зогсоож болох бол гэж эргэцүүлэн бодож суулаа.



62. Сайхан архи дарс, дуу хуур, бүжиг наадам хан хүүгийн сонирхлыг татаж, өтлөх, өвчлөх, үхэхийн тухай хязгааргүй бодлоос салгаж чадахгүй байв. Тэр хүн байх гэдэг бол зорилготой байх, бусдыг зовлонгоос ангижруулах арга замыг эрэх ёстой гэж бодож байв.



63. Хан хүүг унтлагын өрөөндөө ороход хатан, хүү хоёр нь аль хэдийнээ нойрссон байлаа. Тэрээр хатан нь ядарч хөгшрөөд, хүү нь хэзээ нэгэн өдөр ертөнцийн мөнх бусыг үзнэ гэдгийг мэдэж байлаа. Юм бүхэн хувьсан өөрчлөгдөж байдаг мөнх бусын хууль түүний оюунд эргэлдэж байв. Эцэст нь тэр төгс гэгээрэлд хүрэхийн тулд бясалгалын амьдралыг дагах үнэний эрэлд гарах, улмаар хүмүүсийг зовлонгоос ангижруулахаар хатуу шийдэв.



64. Хан хүү өөрийн хүсэлдээ хөтлөгдөн зуны ордоноосоо гарч морины жүчээнд очиж хамгийн сайн мориндоо мордож, ер бусын аялалдаа гарав. Тэрээр бараа бологч Чандакадаа: Би үхэл амьдралын асуудлыг шийдэхийн тулд үнэний эрэлд, зовж буй олон түмнийг амирлуулахын тулд хуврагийн амьдралыг сонгож явах боллоо гэв.



65. Үүнийг сонсоод Чандака балмагдан, мөргөж ордноос гарч явахгүй байхыг гуйв. Гэвч хан хүүгийн хүслийг хэн ч хорьж чадахгүй гэдэг нь ойлгомжтой байсан тул аргагүйн эрхэнд дагалдан явлаа.



66. Хан хүү нисэх мэт давхисаар нэгэн уулын хормойд ирэхэд түүний өмнө даяанч нарын их ой харагдав. Тэр морио услаж амраагаад: Би одоо ганц биеэр үнэний эрэлд мордлоо та ордондоо буцна уугэж Чандакад хэлэв.



67. Чандака газарт сөхрөн сууж уйлав. Хан хүү түүндүнэтэдлэл, хувцас, хааны титэм, эрдэнийн чулуунуудаа бүгдийг өгөөд хаан аавдаа энэ тухай дуулгахыг захиад, хүний зовлонг ангижруулах арга замыг эрж олохоор даяанч нарын ой руу явж одлоо.



68. Чандака эргэн эргэн харж явтал хан хүү эрдэнийн сэлмээ гаргаж үсээ огтлон хаяхыг харав. Чандака ордондоо ирээд энэ бүхнийг хаан эзэндээ айлтгав.




69. Даяанч нарын ойд олон тооны бясалгагч
бярман байв. Хан хүү тэдний хамгийн
ахмадаас нь: Хэрхэн би үнэнийг эрж олох
вэ? Муу муухайгаас яаж ангижрах вэ?
Хэрхэн гэгээрэх вэ? гэж асуув.



70. Тэр бярман:

- Бид хойд төрөлдөө аз жаргалтай амьдрахын тулд найдан бясалгалыг чармайн хийдэг. Харин бид гэгээрэл, чөлөөлөгдөхийн тухайд юу ч мэдэхгүй гэжээ.



71. Цааш хэлсэн нь: Бид өлсөж байхдаа өвсний үндэс, холтос, цэцэг, жимс иддэг. Заримдаа бид өдөржин хүйтэн ус толгой дээрээ цутгадаг, бид биеэ дулаацуулах гэж галын дэргэд унтдаг. Мөн модны мөчир дээр толгойгоо доош нь харуулж дүүжлэн хэвтдэг. Бид бясалгалын олон арга хэрэглэдэг. Энэ бүхэн бол нар, сар, од, гал, усанд хүндэтгэл үзүүлж наминчлан залбирч байгаа хэрэг юм гэжээ.



72. Бярманы тайлбарыг сонсоод мэргэн хан хүү: тэдэнд үхэл амьдралын тухай ойлголт алга, тэд амьд амьтныг аврах байтугай өөрсдийгөө ч зовлонгоос чөлөөлж чадахгүй, үндсийг нь хаяж үзүүрийг нь шүүрч байгаа юм байна гэдгийг мэдэж авлаа. Бясалгагчид зүгээр л өөрсөддөө зовлонг нэмж байна. Ийм болохоор хан хүү тэднийг орхиод бусад даяанч нар байгаа газар руу явж одлоо.



73. Хаан хүү ордныг орхин одсон нь ордныхны гайхширлыг төрүүлэв. Хаан Судаана, Чандакийг ганцаараа буцаж ирэх үест өндөр тушаалын түшмэлүүдийг ордондоо цуглуулан хуралдуулж байлаа.



74. Өндөр тушаалын түшмэдүүд ам уралдуулан Чандакийг хатуузэмлэж байв. Чандака яахаа ч мэдэхгүй,гэмшин уйлж гуниглан суув.



75. Эзэн хаан тайвнаар юу болсныг ярь хэмээн тушаасанд:

-Чандака, хан хүү хэрхэн даяанчдын ой руу очсон тухай, үсээ хэрхэн тайрч хаясан тухай уйлан байж ярилаа.



76. Хаан машинд бухимдсан боловч, Асита даяанчийн урьдчилан хэлсэн үг санаанд нь орж энэ явдал гарцаагүй болох ёстой байсан гэдгийг ойлгоод биеэ барив. Тэр дээд түшмэдүүдтэй хан хүүг буцаан ирүүлэх ямар арга байна вэ? гэж асуун хэлэлцэв.



77. Зөвлөлдсөний эцэстхан хүүг буцааж ирэхийг ятгахаар таван хүнийг томилон явуулах болов. Үүнд: Ажната-Каундия, Асважит, Бхадрика, Дасабала-Касяпа, Маханама-Кулька нар даяанч нарын ойд очиж хаан хүүг буцаан авчрах тушаал аваад хөдөллөө.



78. Хан хүүг ордноос явсныг дуулаад Девадатта баярлан хааны сууринд суух цаг минь өөрөө ирэв хэмээн боджээ. Гэвч хаан хүүгээ авчруулахаар таван түшмэлээ илгээснийг сонсоод атаа хорсол нь хөдлөж, хэрхэн хориг саад болох вэ? гэж санааширав.



79. Девадатта таван хүний нэг Кулькатай нууцаар уулзаж хуйвалдан, хэрхэн санасандаа хүрэх ов мэх зохиолоо.



80. Девадатта түүнд даалгавраа амжилттай биелүүлбэл өндөр шан харамж өгнө гэж амлан ятгаж байгааг Каундияа сонсож балмагдлаа.




81. Таван түшмэл дараа өдөр нь хааны зарлиг ёсоор ой руухөдлөхөд Девадаттатай хуйвалдсан Кулька ч тэдний дунд хамт явалцав.



82. Харин хуйвалдааныг мэдэх Каундияа сэрэмжлэн, Кулькагийн хөдөлгөөн, алхам болгоныг хянаж явлаа.



83. Тэд даяанч нарын ойд дөхөж явтал Каундияа зориуд хоцров. Үлдсэн дөрөв нь түүнийг хүлээж байтал гэнэт нэг зайдан морь модон гүүр чиглэн давхиж байгааг харцгаав.



84. Тэд гайхан ажиглаж байтал өмхөрсөн модон гүүр хэмхэрч гүүрний дунд хэсэгт давхиж хүрсэн морь уулын голд ойчжээ.



85. Кулька модны арднуугдан энэ бүхнийг харж зогслоо.



86. Үүний дараа тэр нөхөддээрээ гэм зэмгүй мэт хүрч ирэхэд нөхөд нь юуч болоогүй мэт байлаа. Гэвч Кулькагийн гэмт харц Каундияагийн гярхай харцнаас мултарч чадсангүй.



87. Бясалгалын ширэнгэнд нэг өвгөн сууж байхыг хараад тэд хан хүүг сураглав.




88. Тэр даяанч ямар ч хариу үг дуугарсангүй дүлий дүмбэ царайлан өчүүхэн ч хөдлөлгүй суусаар байх үест Бхадрика тэсвэр нь барагдаж чанга дуугаар хашгиран асуусанд ч тусыг эс олов.



89. Каундияа Бхадрикаг ятган болиулаад өөр хүнээс явж асууцгаая гэв.



90. Гэнэт Асважит цочин хашгирч модон дээр байгаа юмыг заан үг дуугарч чадахгүй балмагдав.



91. Тэдтүүний зааж буй газар өөдхартал модноос дүүжлэгдсэн, үс нь унжсан хүн байхыг үзээд очиж модноос буулгалаа. Тэр яс арьс болтлоо турсан байв. Энэ бол даяанч нарын өөрийгөө тарчилган зовоох нэг арга байлаа.



92. Цаашлаад зарим нь ярихаас татгалзсан, зарим нь өөрийгөө шатаасан, зарим нь гар мөчөө нүхэлсэн, зарим нь юу ч идэхээс татгалзсан гэх зэрэг олон даяанч нарыг үзлээ.



93. Ингээдцаашилсан боловч хан хүүгийн мөрийг гаргаж, сургийг сонссонгүй. Тэд маш их ядарсан тул түр амарч гүн нойронд дарагдав.



94. Тэднийг амтат нойрондоо нойрсож байхад хэн нэгэн нум сум агсаж, хорлохыг завдаж байв.



95. Нум сум агссан хар сүүдрийн сумны үзүүр Асважитруучиглэж байв. Гэтэл түүний араас бас нэгэн хар сүүдэр гарч ирж тэр хоёр сүүдэр өндөр модон дээрээс өтгөн өвсөн дунд ойчив.



96. Унасан хоёрыг хоорондоо барилцаж зодолдож байх үед Асважит нойрноосоо сэрэв. Сайтар нягтлан харваас нэг нь Кулька, нөгөө нь Каундияа болохыг мэдэв. Асважит тэднийг ятган зодолдохыг болиулав.



97. Кулька өөр муусанаа агуулж, тэднийг хорлох гэж байна гэдгийг Каундияа олонтой хэлсэн боловч, Кулька ердөө ч хүлээн зөвшөөрөхгүй байв.



98. Тэднийг ид маргаж байхад ширэнгийн дундаас гэрэл цацрав. Тэдмаргаанаа зогсоож гэрлийн зүг гайхан явав.



99. Хан хүү Сэдэдраднаа даяанч нарын ойд даяанч нараас мэргэн ухааныг эрж олохыг оролдсон боловч хэн ч түүндсэтгэл ханамжтай хариулт өгсөнгүй. Ийнхүү тэр амьдралын энэ замыг орхиод, ганцаараа Гаяа уул руу бясалгал даяанчлалд суралцахаар одов.



100. Хан хүүгийн амьдрал маш энгийн байлаа. Тэр бүхий л хүчээ суралцахад зориулж өдөрт зөвхөн нэг ширхэг арвайн улаан буудай идэж, чин зоригоор бясалгал хийж байсан учир түүний бие өдрөөс өдөрт хатингарч турж эцсээр байв.



101. Каундия болон түүний нөхөдгэрэлтэх туяаг дагасаар яваад эцэст нь хан хүүг олжээ. Түүнийг яс арьс боллоо турсан байхыг үзээд маш ихэд харамсацгаав.



102. Тэд анхнаасаа хан хүүг буцааж авч явах зорилготой ирсэн боловч хан хүүгийн ган төмөр мэтзориг эрмэлзэл эргэлтбуцалтгүй юм гэдгийг мэдэцгээж, улмаар хааны зарлигийг үл биелүүлсэн хэмээх ял сонсохоос эмээж шавь болон үлдэхээр шийдэв.



103. Хан хүүгийн бэрхшээлт бясалгалын амьдрал нүд ирмэх зуур зургаан жилийн нүүр үзэв. Гэвч хан хүү ухарч няцсангүй харин гэгээрэх их хэрэг зөвхөн бясалгалын эцэст бүтдэггүй юм байна гэдгийг ойлгосон байна.



104. Хан хүү даяанчлалаа зогсоохоор шийдэж Ниранзана голын ариун тунгалаг усаар угаалга үйлдэн, хир бургтаасаа салж, дотоод сэтгэлээ ариусгаж шунал тачаал, уур хилэн, мунхаг мангуу, уйтгар зовлонг огоорч мэргэн ухаанаар үнэнийг олно гэж бат найдаж байлаа.




105. Гэвч хаан хүүгийн бие нь удаан жил бясалгал даяанчлал үйлдсэн, туйлын ихээр доройтсон тул голын эрэг дээр гарч ирээд муужран унав.



106. Азтай нь тэр үед Нанда гэгч саальчин охин толгой дээрээ ваартай сүү тавьчихсан явж байгаад, ядарч туйлдсан хан хүүг олж хараад нэгэн бадар аяга үнээний сүү түүнд уулгав.



107. Саальчин охины өгсөн сүүг хан хүү хүртээд амтат цэцгийн бал уусан мэт болов. Хан хүү маш хурдан сэргэж тэнхэрлээ. Шүүдрийн ус мэт ариухан, амт нь юутай ч зүйрлэшгүй байлаа. Сүүг уумагц зүдэрсэн бие тэнхэрч хүч тамир орж эхлэв.



108. Яг энэ мөчид Каундияа болон түүний нөхөд нь хан хүү саальчин охины үнээний сүүг ууж байгааг хараад машид гайхав. Тэд хан хүү үзэсгэлэнт бүсгүйн арганд орсон нь юун харамсалтай вэ? гэж эндүүрч зүрх алдан харамсацгаав.



109. Кулька ямар ч үр дүнгүй зургаан жил гашуун зовлон амслаа. Хэрэв Девадаттын хэлснээр хан хүүг эртхэн хороосон бол бага ч гэсэн түшмэлийн зэрэг хүртэж, язгууртны зиндаанд дэвших байсан юм гэж халагласаар сэмээр зугтан одов.



110. Хан хүүгийн сэтгэл сэргэж Каундияа зэрэг шавь нарынхаа зүг явж очтол тэд аль хэдийн сураггүй болсон байв. Хан хүү ширэнгээс холдож Ниранзана голыг гатлан Гаяа уулыг чиглэн явав.



111. Хан хүү шүхэрлэсэн Бодь модны дор байх чулуун суудалд суув. Тэр цаашид үнэнд хүрэх эрлээ үргэлжлүүлэхээр шийдэв.



112. Энэ үедалсаас өвс хадсан хүүхдийн дууялах чимээ сонсогдож хан хүүгийн дэргэдүүр өнгөрөхдөө, түүний ер бусын дүрийг гайхан өөрийн хадсан өлзийт өвсөөр суудал засаж өгөв. Хан хүүгийн бясалгалын суудал аятай болов.



113. Хан хүү жаал хүүд талархлаа илэрхийлээд
“Би үхэх төрөхийн үнэн хязгаартхүрээгүй цагт,
энэ суудлаас босохгүй” хэмээн тангараглав.



114. Нөхдөөсөө оргосон Кулька, хэрэв хан хүүг хөнөөж чадвал Деваддатаас шагнал авч дуусашгүй баялагтай болох шуналдаа хөтлөгдөн буцаж хан хүүг эрсээр байв.



115. Эрсээр нэн удалгүй хан хүүг бодь модны дор бясалгал үйлдэж буйг олж харав. Ямар ч хамгаалах хүн үгүй хан хүүг хорлохоор тэр баруун гартаа сэлмээ бариад зүүн гараараа модны ороонгоос зуурч модөөдавирч гарлаа.



116. Кулька алга болсныг гэнэт анзаарсан Каундияа тэр даруй чангаар хашгирч, нөхөддөө мэдэгдэв. Тэд цөмөөрөө Гаяа уул руу уралдан гүйцгээв.



117. Тэд Гаяа уулын бэлд дөхөж ирэх үестуулнаас нэг хүн өнхрөн, саглагар ногоон дундах намагт ойчихыг харав. Ойртон ирж үзтэл нөгөө оргож алга болсон Кулька байлаа.



118. Кулька уул өөд авирч байхдаа дөрвөн хүн өөрийнх нь араас ирж явахыг хараад нэг хэсэг яах учраа олохгүй тэвдэж сэлмээрээ модны ороонги олсыг тас цавчин доошоо намганд унасан байв.



119. Кулика үхэх тавилангүй байжээ. Түүний унасан цөөрөм нь гүехэн тул бага зэрэг гэмтэж, түр зуур ухаан балартсан байна. Дөрвөн нөхөд нь түүнийг цөөрмөөс гаргаж зүлгэн дээр хэвтүүлэв.




120. Асважит: Бид Кулькаг аврах ёсгүй хэмээн нөхдөө ятгасан боловч, цайлган цагаан сэтгэлтэй үнэнч шударга Бхадрика:Кулька бол өндөр шан харамжны шуналдавтсан хүн. Бидтүүнийг аварвал зохино хэмээн нөхөддөө хэлж ухааруулав.



121. Чөтгөр шулмасын хаан Папияан хан хүү гэгээрлийг олохоор сэтгэл шулуудсаныг сонсоод хан хүү хэрэв гэгээрлийг олбол шулмасын хүч ихээхэн доройтох болно. Иймээс хан хүүг хорлож, гэгээрэлд хүрэх замыг нь таслан түйвээхээр шийдэж цэргээ илгээв.



123. Улмаар тэд борооны дусал мэт, түмэн буман хорт сумаар хан хүүг харвасан боловч хортой сумууд хан хүүгийн биед хүрмэгцээ газарт унаж бадамлянхуа цэцэг болон дэлгэрч, салхины аясаар найгаж байв. Папияан хан хүүтэй зэвсгийн хүчээр тэмцэлдээддийлэхгүй юм байна. Өөр арга бодьё хэмээн шийдэж буцлаа.



124. Гурван чөтгөрийг үзэсгэлэнт бүсгүйн дүрд хувилган, биеийн гоо сайхныг гайхуулан хан хүүг тойрон бүжиглүүлж эхлэв.



125. Гэвч хан хүү эрдэнийн суудлаасаа хөдөлсөнгүй, өнгө гоо үзэсгэлэнд шунасангүй тул шулмасын энэ арга ч талаар өнгөрчээ.



126. Яг энэ агшинд тэнгэрт цахилгаан цахиж аянга буулаа. Шулмасын аймгийг үлдэн хөөхөөр тэнгэрийн харуулууд шидэт таягаа барьсаар сүртэйгээр гарч ирэхэд Папияан цэргүүдээ дагуулан бараа сураг үгүй зугтан одов.



127. Шулмасын аймаг дарагдсаны дараа хан хүү улам ч гуйвшгүй бат итгэлтэй болов. Түүний оюун ухаан улам тайван амгаланг олж самадийн хязгаарт хүрэхийн тулд сэтгэл шулуудав.



128. Хан хүү бодь модны дор бясалгал үйлдэж суусаар, түмэн учир шалтгааныг ялган тэгшитгэж, хураангуйлан ариутгаж чадав. Нэгэн үдэш тэнгэрийн зүүн хаяанд алтан туяа цацруулсаар онцгой нэгэн гэрэлт од тодрон гарч ирэв. Хан хүү одыг олж хараад сэтгэл санаа нь ариусан уужиран цэлмэж, туйлын яруу гэгээрлийн чанадад нэвтэрч, сэтгэл оюун нь агууих энэрэн нигүүлсэнгүй мэргэн ухаанаар бялхав. Ийнхүү тэрбээр одот ертөнцийн үнэмлэхүй дээдүнэний чанадад хүрч Будда болов.



129. Гэрээрсэн бурхан: Энэ ертөнцийн хамаг амьтан сансрын зургаан хүрдэд өөр өөр төрлийг олно. Харин хамаг амьтан гэгээрэх төрөлхийн билэг оюунтай. Гагцхүү тэд өөрсдөө зовлонгийн далайд шумбаж, харанхуй мунхагаас өөрсдийгөө чөлөөлж чадахгүй байгаа юм гэдгийг нэн тод мэдэрч байлаа.



130. Ертөнц дахь амьдралын үнэнийг олж мэдсэн Бурхан дараа нь бодь модны дор хорин нэгэн хоног бясалгал үйлдээд, хязгааргүйн чанад хоосон чанарт хүрч улмаар сургаал айлтган номлохоор суудлаасаа босож Каси хот руу явав.



131. Энэ үест Куандияа нөхдийн хамт Кулькаг аварч тэнхрүүлээд Бугат цэцэрлэгтээ эргэн ирж бясалгалаа үргэлжлүүлж байлаа. Тэдхан хүүг үлэмж гэгээрч, Бурхан болсныг сонсоод ихэд баясан хөөрч, түүнд мөргөн золгож, шавь орцгооё гэж шийдэцгээв. Харин Кулька өөрийн үйлдсэн шившигт явдлаас ичиж, Бурхантай нүүр учран золгохоос эмээж, сэмхэн оргон зайлав.



132. Бурхан Бугат цэцэрлэгт хүрэлцэн ирж тэр дөрвийн хүндэтгэлийг хүлээн авав. Тэд хүлцэл өчиж, саальчин охиноос сүү ууж байсныг хараад буруу сэтгэл төрж байснаа, мөн Кулька хорон санаа агуулж оргон зайлах болсон зэргийг нэгд нэгэнгүй ярьж наманчилан өршөөхийг хүсэв.



133. Бурханы шавь болох Кулькагийн хувь заяа харахан бүрдээгүй учир түүнийг албадах хэрэггүй хэмээн сануулж, Будда тэр дөрвийг өөрийн шавь болгов.



134. Кулька оргоод буцаж Девадаттынд иртэл, тэр ихэд хилэгнэн, хан хүүг цааш нь харуулахгүй бол төрсөн эхийг чинь хөнөөнө гэж сүрдүүлэв.



135. Тав хоногийн дотор хан хүүг заавал хороо гэж Девадатта тушаав. Кулька хэрхэхийг эс мэдэн, хандсан зүг рүүгээ тэнэж одов.



137. Дээрэмчин Ангулимала бие өндөр, чац урт, хүч чадлаар Кулькагаас илүү байлаа. Тэрээр сэлмээ далайж, чангаар инээж Кулькад хэлсэн нь: Чи яг цагаа олоод ирлээ. Би ерэн есөн хүн цааш харуулаад байна. Чи зуу дахь нь болно гэв. Кулька сүнсээ гартал айж амиа аврахын тулд чадал мэдэн зугтлаа.



138. Хэдхэн алхаад Кулька Ангулималад баригдав. Ангулимала тэнгэрийн зарлигаар би зуудахь эрийг хороовол миний нас мянган жилээр уртасна, одоохон чамайг хороож хүслээ биелүүлсүгэй гэв.



139. Кулька ухаан сийлж хэлсэн нь: Хэрэв та над мэтийн дорд амьтныг нухвал тэнгэр таалахгүй дээ. Хамгийн сүүлчийн зорилгодоо Шагжамуныг ашиглавал Бурхан таны амьдралыг үүнээс ч уртасгах байх гэв. Тэр хоёр ярьж тохироод бугат цэцэрлэг рүү маргааш өглөө нь хамт явахаар болжээ.



140. Кулька түрүүлэн ирж Бурхантай уулзаад:
 Ээж маань өвчин олжээ, та явж эмчилж
 туслана уу? хэмээн худал хэлж түүнийг
 дагуулан явж, өөрийн оронд дээрэмчинд
 тушаах хорон хар санаагаа нуун гуйваа.
 Бурхан Будда аль хэдийнэ түүний далд муу
 санааг мэдсэн хэрнээ түүний хүсэлтийг
 дагаж ой руу явав.




141. Кулька Бурханыг дагуулсаар агуйд дөхөж ирэх үедгэнэтихэдгэмшин, ганц ч үг хэлэлгүй модонд хацраа наан цурхиртал уйлчихав.



142. Каудияа болон түүний нөхөд гүйж ирээд Кулькагаас. Чи яагаад энэ аюултай газар барсын аманд Буддаг дагуулж ирсэн бэ? хэмээн асуухад тэрээр хариулж чадахгүй мэгшин уйлсаар байлаа.



143. Энэ бүхнийг аль эрт мэдсэн Будда Ангулималагийн агуйд ганцаараа ирж түүнд хэлсэн нь: Би чиний хүслийг биелүүлэхийн тулд чамд тусалсугай, харин чи өнөөдрөөс хойш ганц ч шавж алахгүй гэж тангарагла гэв. Ангулимала юу ч бодолгүй за гэхжээ.



144. Энэ үед Кулька сэхээ авч Будда, Ангулимала хоёрын хооронд зогсоод Ангулималад: Та намайг цааш нь харуул, харин Буддад бүү гар хүр хэмээн гуйв. Тэрээр нүгэл үйлдсэндээ туйлын харамсан Буддагийн өмнө сөгдөн сууж өршөөл эрэв. Будда тэр хоёрт: Тэнгэр зуун хүний амийг золиослож, нэг хүнд мянган жилийн насыг хэрхэвч үл хайрлана гэж хэлээд учир шалтгааныг ухааруулан номлов.



145. Буддагийн нүүрнээ тодрох их энэрэл хайрыг мэдэрч, түүний айлтгалыг сонсоод Ангулимала сэнхэрч улмаар гар дахь илдээ хөсөр хаяан Буддагаас өршөөл эрэв. Гэмээ наминчилж засч чадна гэж тангаргалав. Ангулимала, Кулька хоёр гэмээ мэдэн ариун нигүүлслийн замаар явахаар шулуудаж үнэний мөрөөр орлоо.



146. Тэр хоёрыг босгогтун хэмээн Будда хэлээд, Каундия, Асванжитад хоёр одооноос эхлэн шинэ хүн болсон гэв. Тэр хоёр ёслон дагах боллоо.



147. Буддагийн хайр өршөөл, дээрэмчин Ангулималаг уяруулав. Тэрээр хорт санаагаа гэж, нигүүлсэнгүй сэтгэл гаргаж шударга үнэнч шавь болохоо амлав. Кулька ч мөн сахил хүртэх болов.



148. Будда Бугын цэцэрлэгт таван хуврагад дөрвөн үнэнийг номлов. Дөрвөн үнэн гэдэг нь:
 Зовлон үнэн
 Зовлонгийн шалтгаан үнэн
 Зовлонгоос ангижрах үнэн
 Зовлонгоос ангижрах зам мөр үнэн юм.
 Зовлон бол хамгийн үндсийн үндэс өтлөх, өвдөх, үхэх зэрэг зовлон хүн бүрд зайлшгүй тохиолдоно. Буддагийн энэ номлол хутагтын дөрвөн үнэн гэж алдаршжээ.



149. Зовлонгийн үндэс бол зовлонгийн шалтгаан шунал, уур хилэн, мунхаг гурван хороос үүсэлтэй. Энэ гурван хор бие, сэтгэл, хэл гурваар дамжин үйлдэгдэнэ хэмээжээ. Энэ бол зовлонгийн шалтгааны үнэн болно.



150. Бид яаж зовлонгоос ангижрах вэ? Бид сахил, бясалгал, мэргэн ухаан гурвыг эзэмшсэнээр уур, мунхаг, шунал гурван хорыг дарж, ангижирч чадна. Үүнийг зовлонг арилгах үнэн хэмээн нэрлэнэ. Энэ бол зовлонгоос ангижрах үнэн болно.



151

151. Зовлонгоос ангижрах зам мөр үнэн гэдэг бол зовлонг арилгах арга юм. Зовлонг арилгахын тулд элдэв төөрөгдөл самуурлаас өөрийгөө чөлөөлж үнэнд тэмүүлэх явдал. Ингэж чадвал гэгээрлийн замыг олно. Хязгааргүй бодь сэтгэлтэй бол өөрийгөө болон бусдыг гэгээрүүлж, төгс гэгээрсэн хүн болцгооно. Иймээс хүн бүрд гэгээрч чадах ариун чанар буй тул хүн бүр бурханы хутгийг олж чадна.



152. Дөрвөн үнэний гол үндэс зарчим бол үйлийн үр юм. Будда: “-Аливаа үйл явдал нь янз бүрийн үйлийн үрээс эхтэй. Одоод ертөнцийн хүмүүний үйл, үзэгдэл цөм харилцан уялдаатай, нэг нь нөгөөгийн шалтгаан болж оршино. Дан ганц тусгаар биеэ даасан үйл гэж үгүй. Тэрчлэн уялдаа, шалтгаан нь үүсэх хөгжих, улмаар мөхөж устахдаа ч үйлийн үртэй холбоотой байдаг юм” гэж сургаж байлаа.



153. Будда таван шавьдаа найман гишүүт зөв замаа номлосон бөгөөд тэр нь энгийн хүмүүн сахиж дагаваас гэгээн хүн болох арга зам юм.



154. Анхны зам нь зөв үзэл. Энэ нь дөрвөн үнэнийг төгс ойлгож ухаарах, энэ ертөнцийн мөн чанарыг мэдэж ялгах үнэнхүү явдал болно.




155. Хоёрдугаар зам бол зөв бодол. Ертөнцийн мөн чанарын учир шалтгааныг зөв ухаарч, улмаар зөвөөр дүгнэж, өөрийн үзэл бодлын жинхэнээсээ залуур болгох явдал юм.



156. Гуравдугаар зам бол: Зөв үг хэл, энэ нь хэрэггүй юм чалчих, хоёр үзүүртэй зүү шиг бусдыг нүгэлд түлхэх, хараах, гүтгэх зэрэг бусдад хор хүргэх аливаа үг яриаг тэвчих, цээрлэх явдал болно.



157. Дөрөвдэх зам бол — Зөв явдал. Бие хэл, сэтгэлийн үйл ариун байх, аливаа үйл явдал шударга зөв байх.



158. Тав дахь зам бол — Зөв харилцаа юм. Энэ нь амьдралын энгийн хэв маяг хэлбэрээр ердийн төлөв амьдрах ба муу бодлоос ангид, амьтан хөнөөх, хулгай тонуул үйлдэх, садар самуун явах, хуурч мэхлэх зэрэг ёс суртахууны болон төрийн хууль цаазны хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл хийхгүй байх.



159. Зургаа дахь зам бол — Зөв хүсэл. Сахил, бясалгал, мэргэн ухааны сургаалын төлөө (гурван ухаан) тасралтгүй чармайлттайгаар сурах.



160


160. Долоо дахь зам бол — Зөв сэтгэл. Дөрвөн үнэнд хүрэх замд нийцсэн залбирал байнга үйлдэж, дөрвөн үнэний тухайд нийцсэн сэтгэл гаргах.



161. Найм дахь зам нь — Зөв бясалгал. Дөрвөн үнэнийг ямагт сэтгэн бодож, сэтгэлээ хатамжилж байх.



162. Буддаг дөрвөн үнэн, найман гишүүт, үйлийн үрийн арван хоёр шалтгааныг номлосны дараа түүний таван шавь ихэд баясаж талархаад, хойшид дагаж мөрдөхөө андгайлав. Тэд энэ цагаас эхлэн Будда Бурханы сургаалыг номлогч, Буддын шашны түүхэнд хамгийн анхны шавь нар нь гэж нэрлэгддэг болсон юм.



163. Каси хотод Яса нэрт нэг залуу хүн байжээ. Түүний сүйтбүсгүй нь хайраа өөр хүндөгчээ. Яса гуниглан сэтгэлээр унаж, улмаар ухаан санаа нь балайрч, хаа сайгүй тэнүүчлэн явах болжээ.



164. Яса нэг удаа гэгээрсэн Буддатай учирч ном сургаалыг сонсоодухаан санаа нь сэргэж, энэ ертөнц дээрх бүх юм мөнх бус, юу ч хамтдаа удаан оршдоггүй гэдгийг мэдэв. Тэр сөхөрч суугаадшавийн эгнээнд багтахыг хүсч улмаар зургаа дахь Бикшү нь болж хожим бурханы хутгыг олсон юм.



165. Ясагийн эх эцэг Каси хотын сурвалжит угсаатан байсан ба хүү нь Буддад шавь орж ухаан санаа нь сэргэснийг сонсоод Буддад талархал илэрхийлж хүндэтгэл үзүүлэв. Ингээд шавь орж сахилын хувцас өмсч анхны Упасака нар болжээ.




166. Бодь модны үр алс холд цацагдах мэт
 Бурханы сургаал улам дэлгэрч, Ясагийн
 тавин найз нөхөд нь нигүүлсэнгүй мэргэн
 ухаанд суралцахаар иржээ. Тэд гэгээрч, сахил
 хүртсэн анхны хуваргын аймгийн үндсийг
 тавив.



167. Будда аялан явж, өөрийн сургаалыг номлож байлаа. Нэгэн удаа төв Энэтхэгийн Маданад явж байх үеэр галыг шүтэгч нарын тэргүүн Урувилвагаас хонох байр хүссэнд тэрээр нэгэн агуй зааж өгөөд, энэ агуйд хорт луу амьдардаг юм. Шөнө дунд болохоор гарч ирж хүн барьж иддэг гэж хэлэв.



168. Будда агуйдорж завилаадтайван суув. Шөнө дундхортлууэрүү амаа хавиран, элдэв сүрийг үзүүлсэн боловч түүнийг айлгаж чадсангүй.




169. Дараахь өглөө нь Бурхан багшийг чулуун агуйнаас эсэн мэнд гарч ирэхэд цугларсан олон маш их гайхаж байв.



170. Ингээд буянт сэтгэлийнхээ хүчээр аймшигт луундидүүлэлгүй гарч ирсэн Бурхан багшийн агууих хүч, сургаал номлолын няцашгүй үнэнд цөмөөрөө бүрэн итгэлээ. Уривилва таван зуун нөхдийг уриалан сахил хүртэж номын хувцас өмсч шавь болцгоов.



171. Бурхан багш Урувилва болоод түүний таван зуун нөхдөддөрвөн үнэний номлолоо айлдсанд, тэд бүгд Бурхан багшийн шавь болж, хаа явсан газар нь дагалдаж, сургаал номлолыг нь сонсож баримталж явахаа андгайлав.



172. Галыг шүтэгч байсан Урувилва бурханы сургаалыг мөрдөх болоод урьд нь хэрэглэж байсан шүтлэгийн эдзүйлсээ Ниранзана голд хаяж устгав. Голоор урсан яваа эд зүйлсийг Урувилвагийн хоёр дүү Накаскапа ба Ганакасипа нарын байгаа газарт урсан очих үест тэд олж харцгаав.




173. Тэд ахынхаа тахилгын эд зүйлсийг таньж, ахыгаа Бурханы сургаалын нөлөөнд автсанд ихэд хилэгнэж, түүнийг аваръя хэмээн ярилцаад тус бүр хоёр зуун тавин нөхдөө дагуулан өдөр шөнөгүй явсаар ирэв.



174. Ах Урувилва ба түүний нөхөд Бурханы шавь болсон учраа тайлбарлаж тэр хоёрыг нөхдийн хамт Бурхан багшид бараалхуулав. Тэд бурханы айлтгалыг сонсоод бишрэн, номын хувцас өмсч шавь орцгоов.




175. Ингээд Урувилва хоёр дүүтэйгээ өөрсдийн дагалдагч хэдэн мянган хүний хамт гал шүтдэг хуучин уламжлалаа орхиж, Бурхан багшийг дагалдан аялж, үнэний сургаалыг олонд хүргэх болсон нь Магадхагийн улсын бүх л давхаргын анхаарлыг татаж эхэллээ.



176. Бимбасара хаан Бурхан багшийн сургаалыг сонсохын тулд заан хөлөглөн Бурхан багшийг угтахаар хот хэрмээсээ гарч бараа болочдын хамт тосч ирэв.



177. Ражагара хотын иргэд хүндэтгэлийн цуваанд оролцож Бурхан багш ба түүний шавь нарыг угтацгаав. Хүндэтгэлийн цуваа таван мод газар үргэлжилж, тал хөндийг бүрхэж, Вултур уулын бэл хүрч байлаа.




178. Бимбасара хаан Бурхан багшидгүн хүндэтгэл үзүүлж ордондоо урьжээ. Хаан бүх түшмэд, бараа бологчид, ард олны төлөөлөгчдийг ордонд цугларахыг зарлиг болгов.



179. Цугларсан олны өмнө Бурхан багш энэ ертөнцийн хоосон чанар, орчлонгийн мөнх бусын тухай сургаал айлдав. Хаан тэргүүтэн бүх хүмүүс Бурханы сургаалын үнэн няцаашгүйг ухаарч шавь нь болцгоов.



180. Хаан бурхан багш болон шавь нарт нь зориулж Ражагард хотын Каранда хэмээх газар том сүм бариулж өгөхөөр шийджээ.



181. Энэ сүрлэг сайхан ордон арван зургаан том хашаа, хашаа бүр нь жаран өрөө бүхий байшин, мөн таван зуун байр, уншлагын далан хоёр өрөө зэргээс бүрдэж байлаа. Энэ бол Векувана дахь алдарт “Хулсан төгөл” гэж нэрлэгдсэн Бурхан багш ба шавь нарынх нь ном айлддаг төв болсон юм.



182. Шарипутра, Маудгальяна нар тус бүр зуун хүн дагуулан ирж шавь орсон буюу хожим нь бурханы их сургаалыг дэлгэрүүлэх гол туслагч хүчин болсон юм.



183. Нэгэн өдөр Вултур дэх ууланд Бурхан багшийг ном айлдаж байх үед түүний шавь Шарипутра, олон жил бярманы эрдэмд суралцсан өөрийн нагац Махакаустилаг авчирч танилцуулав. Махакаустила өөрийн үзэл бодлыг хамгаалж Бурхан багштай ном хаялцан удаан мэтгэлцсэн боловч дийлдэж улмаар шавь оров.



184. Махакутила нэрт эрдэмтэй, баян бярман байнга сүмдочиж Бурханы сургаалыг сонсдог байжээ. Гэтэл нэг удаа Бурханы сургаалыг сонсчихоод буцаж явтал саяхан ном айлдаж байсан Будда нэгэн саглагар бодь модны дор суучихсан бясалгал үйлдэж байхыг харж мэл гайхаж гэнэ. Үнэндээ Будда номын хүчээр шид үзүүлсэн нь тэр байсан юм.



185. Ражагара хотын Сура нэрт өвгөн Бурханыг гэртээ урьж өргөл өргөө гэж шийдээд бэлтгэлээ базааж байтал хуучин анд Судатта зочилж ирж гэнэ. Судатта аль хэдийнээс Бурхан Буддагийн тухай сонсож, агуу нэр хүнд, билэг авъяасыг нь бишрэгч нэгэн байлаа.



186. Судатта хурдан морь хөлөглөн өдөр шөнөгүй давхиж Бурханыг залахаар хулсан төгөлд хүрэлцэн ирэв. Гэтэл замын дунд Буддатай учирч өөрийгөө танилцуулж, насаар ганц бие явж “Гоонь эр” хочтой болсноо хэлжээ.



187. Сарны саруул гэрэл доор Будда түүнд сургаалаа айлдав. Судатта хоромхон зуурд гэгээрчээ. Тэрээр: -Би нутагтаа буцаж очоод Бурхан танд зориулж мөргөлийн сүм байгуулж өргөл өргөнө гэв. Өгөөмөр сэтгэл гаргаж өглөгийн эзэн болох гэж буйд бурхан ихэд талархав.



188. Сравасит хот хэдийгээр том ч гэлээ, цэцэрлэг модтой газар цөөвтөр болой. Гагцхүү хан хүү Жетагийн цэцэрлэг уужим талбайтай, модургамал, нуур цөөрөм элбэгтэй байгалийн төгс үзэмжтэй болох тул Судатта хан хүүтэй уулзаж та цэцэрлэгээ надад худалдана уугэж хүсэв.



189. Энэ цэцэрлэг бол хан хүү Жетагийн хамгийн хайртай, үнэтэй цэцэрлэгийн нэг байсан тул тийм ч хялбархан худалдах тухай ярилгүй, харин цэцэрлэг үлэмж үнэтэй болох тухай хэлээд цэцэрлэгийн талбайг битүү хучиж чадах хэмжээний алтан тоосгоор бол худалдаж болох юм гэж Судаттад санал болгов. Судатта энэхүү хатуу болзлыг хүлээн зөвшөөрөв.




190. Гэртээ буцаж ирээд Судатта зоориноосоо бүх алтан тоосгонуудаа гаргаж хан хүү Жетагийн цэцэрлэг рүү зөөлгөж алтан тоосгоор хучиж эхлэв. Хан хүү Жета уг нь Судаттаг айлгах гэж бодсон авч одоо түүний цэцэрлэгийг алтаар өнгөлж байна гэдгийг сонсоод ихэд балмагдав.



191. Газар нь хэдийгээр алтан тоосгоор хучигдсан боловч мод ургамал нь хан хүү Жетагийн мэдэлд байлаа. Судаттагийн өгөөмөр, өглөгч сэтгэлд хан хүү Жета ихэд уярч, мод ургамал, алтан тоосго зэргийг мөргөлийн шинэ сүмд хандив болгон өгч байгаагаа мэдэгдэв. Ийнхүү шинэ мөргөлийн газар, Жетавана хийд цогцлон сүндэрлэсэн түүхтэй юм.



193. Жетавана хийдийг дуусах дөхөж байх үест нэг хэсэг тэрсүү үзэлтэн хорон санаа агуулж тэдний үзэл бол Бурханыхаас хол давуу юм гэдгийг харуулахын тулд халз мэтгэлцье гэж уриалав.



194. Мэтгэлцэх тухай мэдээ Сравасти хотоор тарж мэтгэлцэхээр товлосон өдөр болоход олон зуун хүн зүү орох зайгүй цугларчээ.



195. Тэрс үзэлтэн нар өөрсдийн шилдэг арван хүнийг томилж мэтгэлцээнд оруулав. Харин Бурхан багш өөрийн шавь нараас ганц Шарипутраг томилов. Мэтгэлцээн болж хэл ярианы уран, оюун билгийн гүнээр Шарипутра сэргөлдөгч нарынхаа амыг таглаж хэлэх үггүй болгож байлаа. Эцэст нь тэрс үзэлтэн нар ялагдаж улмаар номын хувцас өмсч шавь оров.




196. Бурхан багш өөрийн нэг мянга хоёр зуун тавин шавиа дагуулсаар Венувана хийдээс саяхан цогцлон боссон шинэ хийд Жетаванад хүрэлцэн ирэв.



197. Тэднийг Сравасти хотод хүрч ирэхэд гудамжны хоёр талаар хотын иргэд баяр хүргэн мэндчилж байв. Мөн шинэ хийд Жетавана цогцлон боссоныг өргөн дэлгэр тэмдэглэв.



198. Агуу Будда өөрийн шавь нарын хамт Жетавана хийдэд сууж ариун үйлээ үргэлжлүүлж, Бурханы номлолыг айлдаж байв. Тэдний нэр хүнд өдөр ирэх бүр өсч байлаа.



199. Кошалагийн эзэнт улс нь хойд Энэтхэгийн том улсын нэг юм. Түүний хаан Прасенажит энэ сайхан мэдээг сонсоод Бурханы шавь болохоор морилон ирлээ.



200. Сравасти хот Бурхан багшийн төрсөн газар Капилавастугаас үлэмжхэн хол билээ. Судадана хаан, хан хүү бурхан болсныг мэдсэн ба түүнийг ордондоо эргэж ирээсэй гэж мөрөөдөж байв. Гэвч хүн томилж явуулахаас зүрхшээж байсны учир нь таван шавь нь буцаж ирүүлэхийг хориглох магад гэж бодсоных байлаа.



201. Жетавана хийдийг барьж дууссан мэдээ ирэхэд Судадана хаан магнайгаа хагартал баярлан, хамгийн итгэлт сайд Уданиг хан хүүд баяр хүргүүлэхээр илгээв. Удани эргэж ирэхдээ үсээ хусуулж хуваргын хувцас өмсч бурханы шавь болчихсон байлаа.



202. Хан хүү долоо хоногийн дараа Капилавасту ирнэ гэсэн сайхан мэдээг Удани хүргэж ирэв.



203. Энэ сайхан мэдээ хот даяар тархаж айл бүр гэр орноо цэвэрлэж, ариусгаж завгүй байв. Эр, эм залуу хөгшингүй агуу Буддад талархахаар гадаа жагслаа. Бүх эзэнт улс тэр чигээрээ баяр цэнгэл аз жаргалд умбасан байлаа.



204. Девадатта ганцаараа энэ мэдээг сонсоод сэтгэл нь их зовж байв. Эцэст нь Бурханыг хорлохын тулд өөрийн талын хэдэн хүнийг цуглуулж арга мэх зохион зөвлөлдөв.




205. Девадатта догшин зэрлэг хирсүүдийг төмөр хашаанд хориод, Бурханыг дэргэдүүр нь өнгөрөхөдгусгай дохио өгч зэрлэг адгуусуудыг суллаж дайруулахаар тохиролцов.



206. Будда шавь нарынхаа хамт ирэхэд Девадатта түүнийг угтаж талархаж буй мэт дүр үзүүлэн мэнд амраа мэдээд удаагүй байтал, олны дунд гэнэт үймээн шуугиан дэгдэж эхлэв. Хүмүүс сандралдан үймж зугтахаар завдав.



207. Үүнийг хараад Девадатта чангаар инээв.
Энэ дохиог сонсоод нөгөө хүмүүс улангассан
хирсүүдийг хашаанаас нь гаргаж тавив.



208. Девадатта өөрөө хирсний эвэртөртөх шахсанд Бурхан багш түүний амийг аварчээ. Энэ аймшгаас балмагдсан Девадатта уурлах талархах алиныгаа ч мэдэхгүй алмайран балмагджээ.



209. Хирсүүд цугларсан олныг түйвээн бужигнуулж байх үед гэнэт нэгэн том биет заан гарч ирж улайрсан хирсүүдийг довтлон зогсоов.



210. Бүх хирсүүдийг хөнөөж хамаг хүчээ шавхсан заан хөсөр ойчиж, тэрийн унаж амьсгал хураав.



211. Будда болон олон хүмүүс заан дээр ирлээ. Тэд олон хүмүүсийг аварч амь насаа золиослосныг нь хүндэтгэн заанд цэцэг өргөв.



212. Бурханыг хотод орж ирэхэд бүх л эзэнт улс найр цэнгэлд шумбан орлоо. Будда эзэн хааны ордонд ирэхэд хатан Яшодхара хүү Рахул нар нь түүнийг угтан золгов.



213. Будда Рахул хүүгээ тэврэн, Яшодхара хатанд хэлсэн нь: Энэ хугацаанд та бүхэн их зовлон амслаа, би сэтгэлийнхээ гүнээс харамсал илэрхийлье, одоо би өөрийн тавьсан сахил зорилгодоо хүрлээ. Та нар миний азжаргалыг хуваалцах болно гэж найдаж байна гэв.



214. Суддана хаан Буддаг ном айлгаж өгөхийг хүссэнд: Будда зовлон, хоосон чанар, юмс мөнх бус болох тухай айлгаж, гэгээрэлд хүрэхийн тулд мөрдвөл зохих найман гишүүнт үзлээ номлов. Хурсан олон номын хуриманд умбалаа.



215. Будда, хэд хэдэн удаа ордонд номын чуулганыг явуулжээ. Эзэн хааны олон дээдсүүд сэтгэл нь ихэд хөдлөв. Тэдний дунд Аханда, Анирудда, Бхарда, Бхаса бүгд хуварга болохыг хүсч байлаа. Бүр Буддад үргэлж дайсагнаж байсан Девадатта ч бусад хан хөвгүүдийн адил түүнд захирагдахаар гуйсанд Будда тэдний хүсэлтийг ёсоор болгов.



216. Боол удмын Упали гэдэг нэртэй үчин жанч нөмөрч сахил хүртэхийг хүссэнд Будда түүний үсийг авахуулж, шавь оруулав. Будда үүгээр хүн бүхэн тэгш эрхтэй байх ёстой гэдгийг харуулсан ба энэ нь зиндааны тогтолцоотой Энэтхэгийн бярман язгууртнуудын эсэргүүцэл дургүйцлийг төрүүлээ.



217. Үүний дараа удалгүй Буддагийн хүү Рахул жанч нөмрөхийг хүссэн. Гэвч Санхяа бүлгийн дунд урьд нь хүүхэд ийм сахил хүртээгүй байсан ажээ. Будда бандийн арван сахил гэдгийг тогтоож, Рахул шашны түүхэнд анх удаа банди болжээ.



218. Суддана хааны бас нэг хан хүү Нанда түүний хоёр дахь эхнэр Пражапатаас төрсөн юм. Нанда маш сайхан эр боловч сэтгэлийн цэнгэлд хорхойтой. Будда түүнийг нь болиулахыг хүсдэг байлаа. Нанда Капилавастугийн арван зургаан хотод байхгүй тийм үзэсгэлэнтэй Сүндари гэдэг бүсгүйтэй гэрлэчихжээ. Нанда, улсын хэргийг огт хамаарахгүй, зөвхөн биеийн цэнгэлийг эдлэн жаргадаг байв.




219. Нэгэн өдөр Будда бадар аяга бариад Нандагийн ордонд хоол гуйсаар иржээ. Нанда өөрийн ах Буддаг хоол гуйж явна гэдгийг сонсоод яаран гарч аягыг нь тосон авч хоол хийгээд иртэл Будда цааш алхан явж байна гэнэ.



220. Нанда араас нь хөөж гүйлээ. Гайхалтай нь маш хурдалсан боловч Буддаг гүйцсэнгүй.



221. Нанда, Буддагийн араас гүйсээр Вихара хийдэдүүлзлаа. Будда түүнийг хүлээж аваад лам болох уу? гэж асуужээ.



222. Нанда ахыгаа тоглож байна гэж санаад юу ч бодолгүй тэгье гэж гэнэ. Будда Шарипутраг дуудаж яг одоо Нандагийн үсийг авч сахил хүртээ гэв. Нанда хэдийгээр сэтгэл дундуур байсан ч Буддагийн сүр хүчинд балмагдаж хэлсэн үгнээсээ буцах тэнхэлгүй сахил хүртжээ.



223. Нанда хэдийгээр жанч нөмөрч сахил хүртсэн ч мөнхүү ухаанаа төвлөрүүлж эс чадан, юм л бол хайртай эхнэрээ санаж үгүйлж байв. Нэгэн удаа Будда түүнийг дагуулан явж хөгшин эм сармагчин байхыг хараад хөгшин эм сармагчин танай эхнэр хоёрын хэн нь муухай, хэн нь үзэсгэлэнтэй вэ? гэж асуусанд Нанда: Тэнгэрийн дагина шиг гоо үзэсгэлэнтэй миний эхнэрийг хөгшин сармагчинтай яхан зүйрлэж болохсон билээ гэж эргэлзэлгүй хариулав.



225. Энэ дагинасыг Сүндаритай зүйрлэвээс ямар вэ? хэмээн Будда Нандагаас асуухад: Энэ дагинас хэлэх үгээр дүрслэх аргагүй үзэсгэлэнтэй юм. Тэд үнэхээр сэтгэлийг минь булааж байна. Сүндарийг тэд нартай зүйрлэвээс, тэр маань хөгшин сармагчин мэт гэжээ.



226. Нанда тэнгэрийн оронд ганц ч эрчүүд үгүй дагинасаар дүүрсэн байгааг олж мэдлээ. Тэр нэг дагиныг хүсчээ. Тэр дагина хааны суудлыг заагаад: “Энэ суудал бол тэнгэрийн эзний суудалдоогоор түр чөлөөтэй, Буддагийн шавь Нандаад үлдээсэн юм. Түүнийг тэнгэрт тодрох үед энэ суудлыг өгнө” гэжээ. Үүнийг Нанда сонсоод ихэд баярлаж энэ мөчөөс эхлэн Сүндарийг бодохоо болив.



227. Хүний ертөнцөд эргэн ирснийхээ дараа ажил үйлстээ маш их чармайж уйгагүй бясалгал үйлдэж, тэнгэрийн оронд дахин төрнө хэмээн ухаанаа төвлөрүүлэх боллоо.



228. Нэгэн өдөр Будда Нандыг дагуулж өөр газраар аялаж гэнэ. Урт урт мөсөн хонгилд хутга мэт уулс, жад мэт модод арзайн сэрийж, мөсөн агуй, гал дүрэлзсэн нүхнүүд энд тэнд байх нь тамыг санагдуулна. Том тогоонд ус буцалж байгааг Нанда харж, түүний хажууд унтаж байсан эрлэгийн элчийг сэрээхүй дор.



229. Тамын элч хэлсэн нь: Энэ тогоотой тос Нанда гэдэг хүнийг гэсгээхээр бэлтгэгдсэн юм. Тэр бол бурханы хуварга болохоор зарлиглагдсан боловч тэнгэрийн оронд төрөхөөр ам өгсөн. Гэвч тэнгэрийн орон дахь амьдрал нь дуусахаар үйлийн үрийнхээ зургаар тамд унаж таарсан шийтгэлээ амсах ёстой юм. Би түүнийг хүлээж байна гэжээ.



230. Нанда үүнийг сонсоод маш их айж бурханы өмнө наманчлаад тэнгэрт төрөхийг хэзээ ч хүсэхгүй, оюун ухаанаа зөв удирдаж, дахин дахин төрөл арилжихаас чөлөөлөгдөж нирван больё хэмээжээ.



231. Нэгэн зун Будда “Тасын оргил” ууланд заларч байхдаа яах ч аргагүй уй гуниг төрж, эцгийнх нь бие муу байгааг мэдэрчээ. Удаж төдөлгүй эзэн хааны элч ирж, эцгийн тань бие чилээрхэлээ, хааны ордонд яаралтай ир хэмээсэн юм.



232. Энэ мэдээг авмагц ганц мөч ч хүлээсэнгүй,
Нанда, Ананда, Рахул бусад шавь нараа аваад
Капилавасту руу одлоо.



233. Ерэн гурван насыг зооглосон Судадана хаанд амь алдахын аюул нүүрлэж, ордонд уй гашуудал болж байв. Эзэн хааны ордонд Буддаг заларч ирэхэд хатад уйлан мэгшиж байлаа. Будда тэднийг тайвшруулаад эцгийн ор өөд очмогц амь насанд нь хэдхэн хормын мөч үлдсэнийг мэдрэв. Судадана хаан, Буддагийн гарыг чанга атган, мэлмийг нь нулимс бүрхээд ганц ч үг хэлж чадсангүй.




234. Будда эцэгтээ хамгийн гайхамшигт мөнхийн баяр хайр цэнгэлийн орон байдгийг хэлж өгөв. Тэр эцгээ Аминдаваа бурханы нэрээр тэр ордонд төрөл олохыг залбирч итгүүлэв. Ингэж Судадаана хаан Аминдаваа бурханы нэрээр, тэнд байсан хүмүүсийн чимээгүйхэн, нам гүм залбирлын дунд бурханы оронд заларлаа.




235. Хатагтай Пражапат, Яшодара нар шарилын хоёр талд хүндэтгэл үзүүлж зогсоно. Судаданагийн цогцсыг хайрцаглаад гоёмсог цэцэг, үнэт эрдэнийн чулуугаар дүүргэв. Шарилыг эзэн хааны ордонд ёслол төгөлдөр байрлуулсан нь бүх сайд түшмэдүүд сүүлчийн хүндэтгэл үзүүлэх боломж бүрдсэн байлаа.



236. Оршуулгын ёслолын өдөр Будда хүмүүний их багш хэдий ч эцэг эхийн хариулж баршгүй ачийг санаж, өөрийн дөрвөн шавийн хамт эцгийн шарилыг өргөн явалцав. Энэ нь ёс төрд нийцэж, цугларсан олны сэтгэлийг уяраасан онцгой үйл явдал боллоо.



237. Капилавасту хотын иргэд бурхан Буддаг эцгийн ачийг хариулж, ёс гүйцэтгэж явааг харж ихэд бишэрч сөгдөн мөргөж хүндэтгэл үзүүлж байлаа.



238. Миний эцэг ертөнцийн жам ёсоор мөнх бусыг үзүүлэв. Хүү нь болж төрсөн би түүнийг холын замд үдэж байгаа нь хүний ёс хэмээн Будда айлдав.



239. Буддагийн төрсөн эх Маяа хатан түүнийг төрүүлээд долоо хоносны дараахан тэнгэрт халисан бөлгөө. Будда гэгээрсний дараа Тудра тэнгэрт очиж ээждээ зориулж буян үйлдэн ном айлдсан нь Бодисадваг магтсан айлтгал гэж нэрийдэх болсон ажгуу.




240. Буддагийн нэг шавь Маудгалаана архад болсныхоо дараа, билгийн нүднийхээ чадлаар өөрийн эхийг бирдийн оронд төрөл олж зовж гаслаж байгааг олж харсан байна. Үүнийг Будда мэдээд талийгаач нарыг хойт насандаа сайн төрөл олохыг ерөөн билэгдэж “Улламвана” номлолоо айлдсан нь одоогийн оршуулгын ёс болон үлджээ.



241. Оршуулгын дараа Будда Наматигхан хийдэд түр саатаж байх үед нагац эгч Паражапати Шагж омгийн таван зуун эмэгтэйн хамтирж Буддад золгон, шинэхэн оёсон хоёр жанч өргөсөнд Будда: Би бол бурханы шавь нарын нэгэн билээ, би нэг л жанчыг авъя, үлдсэн нэгийг нь өөр бусдад өгнө үү? гэв.



242. Паражапатийн удирдан ирсэн таван зуун бүсгүй сахил хүртэж шавь болохыг хүссэн боловч Будда эс зөвшөөрчээ. Гэтэл тэдсэтгэл нэгэнт шулуудсан байсан тул өөрсдөө үсээ хусуулж, хуврагын хувцас өмсөж ирцгээв.



243. Үсээ авахуулсан хуварга хувцастай таван зуун эмэгтэйг хараад Ананда маш их гайхсан боловч шалтгааныг нь асууж мэдээд сэтгэл амар болжээ. Харин Паражапати тэдэнд сахил хүртээхэд туслана уу? гэж Анандаас гуйв.



244. Паражапатигийн хүсэлтийг ёсоор болгохыг бурхан Анандад зөвшөөрөв. Улмаар гэлэнмаагийн сахил ба хүндэтгэж мөрдвөл зохих найман зарчмыг номлов. Үүнээс хойш эмэгтэйчүүд бурханы үйлд оролцох болсон байна.



245. Өрхийн тэргүүн Судатта Буддад шавь орсны дараа хүргэн бэр нартаа гэр бүлээ Бурханы ёс номын дагуу удирдан залж байхыг хүсчээ. Гэвч түүний бага хүүгийн эхнэр Юйэх өөрийгөө гоо үзэсгэлэнтэйд тооцож ямагт давилуун зан гаргаж, бусдыг дорд үзэн, хадам болон бэргэнээ үл хүндэтгэн улмаар гэр бүлд таагүй байдал буй болгож байв.



246. Өрхийн тэргүүн Судаттагийн бусад зургаан хүргэн, бэрүүд бурханы сургаалыг сонсохоор Жетавана хийдэд байнга очигцооно. Гагцхүү Юйэх ёс журамгүй, дураар аашлах тул төвөгшөөж байлаа. Судатта яах учраа эс олж Буддагаас тусламж гуйдаг юм билүү? гэж бодох болжээ.



247. Судатта Буддатай Жетавана хийдэд уулзаж учир явдлаа ярих гэтэл Будда байдлыг аль хэдийнээ мэдчихсэн!

- Юйэх надтай уулзахыг хүсэхгүй байгаа бол би маргааш танайхаар нэг ороод гаръя гэж хэлжээ.



248. Маргааш өдөр нь Будда шавь нараа дагуулсаар Суддатын гэрт ирэв. Юйэхээс бусад нь бүгдээрээ гадагш гарч хүндэтгэн угтав. Юйэх байхгүй байгаад Судатта сэтгэл их зовж байсан боловч та тайван бай гэж Будда түүнийг тайвшруулж байлаа.



249. Яг энэ мөчид Буддагийн биеэс тоолшгүй олон алтан туяа цагарч, туссан газар болгоноо гийгүүлж байлаа. Тэд гэрлийг дагаж хартал Юйэх өрөөндөө нуугдаад хаалганы завсраар Буддаг харж байгаа үзэгдэв.



250. Юйэх хэдийгээр Буддад талгүй боловч сэтгэлдээ уулзахыг хүсч, манай гэрийнхэн юуны учир ийнхүү Буддаг гүнээ хүндэтгэдэг юм болоо гэж эргэлзэн бодож байв. Юйэх Буддагийн барааг хармагц түүний урьдын омголон догшин ихэмсэг зан ор мөргүй арилчих шиг санагдав.



251. Буддагийн биеэс дахиад гэрэл цацрахад Юйэх нуугдах газаргүй болж сэтгэлийнхээ угаас ичив. Нөхөр нь түүнийг Буддад мөргөж ёсло гэж ятгасан боловч Юйэх зүрхлэхгүй байлаа.



252. Бурхан Юйэхт эелдгээр хандан үзэсгэлэн гоо гэж юувэ? Энэ нь үнэндээ чиний бодож байгаа шиг биш, дотроо гоё байна гэдэг илүү чухал, чи зөвхөн гаднаа гоё, харин зүрх сэтгэл чинь гоё биш байвал чи бусдын хүндэтгэл, бахархалыг төрүүлж чадахгүй түүнээс гадна залуунаас түр зуурын, биеийн гоо сайхан мөнх бус шүү гэж сургав.



253. Буддагийн үг Юйэхд үнэнийг бодитойгоор ухаарахад туслав. Тэр өвдөг сөхрөөд бурханы өмнө гүн хүндэтгэл үзүүлэв. Юйэхд Бурханы номлосон сургаал хожмоо “Юйэхийн сургаал” гэж алдаршсан билээ.



254. Цааш үргэлжлүүлж Будда: Хүний эхнэр болсны хувьд өөрийн биеэ зөв авч явах таван дүрмийг, эр нөхөртөө эрхэм сайнаар хандах таван зарчмыг мөрдөж, эхнэр хүний дөрвөн муу зуршлаас ангижрах ёстой гэж сургамжлав. Бурханы сургаалыг сонссон Юйэх үнэнчээр сүсэглэн сэнхрэв. Үүнээс хойш тэднийх Бурханы сургаалыг бишрэн дагагч ариун гэр бүл болсон юм.



255. Нэгэн өдөр Будда Ганга мөрний эргээр явж Магадхагийн Ражагара хотод очжээ. Энэ хотод баян айлын хүү Сужата өглөө бүр өөрийн биеийг усаар шүршиж норгоод хотын захад хүрэлцэн ирж дөрвөн зүг рүү залбиран зургаан удаа мөргөж байдаг байжээ.



256. Үүнийг Будда хараад юуны учир ийнхүү залбирч мөргөдөг юм гэж асуусанд Сужата:

- Энэ бол эцгээс маань уламжилж ирсэн зургаан зүгт мөргөвөл зохих заншил юм хэмээн хариулжээ.



257. Будда модны дор тухлан суугаад:

- Чиний зургаан зүгт хийж буй мөргөл бол үнэнтэй нийцэхгүй байна гэхэд Сужата гайхшираадучрыг тайлж өгөхийг хүсэв.



2᠔8. Будда айлдсан нь: Зүүн зүг бол эцэг эхийг төлөөлнө. Үр хүүхэд нь эцэг эхийн ачийг санаж таван зарчмыг мөрдөх ёстой.

Нэгд: Эд юмаар гачигдуулахгүй байх

Хоёрт: Аливаа сайн муу үйлийг ойлгож мэдэх

Гуравт: Эцэг эхийг хүндэтгэх

Дөрөвт: Эцэг эхийн сургаалыг үл зөрчих

Тавд: Эцэг эхийн сургаалыг дагаж мөрдөх

Харин эцэг эх мөн үр хүүхдийн хойчийн тулд таван зарчмыг эрхэмлэнэ

1: Үр хүүхдээ хүмүүжүүлэх

2: Ёс суртахууны хүмүүжилтэй болгох

3: Энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэлтэй болгох

4: Гэр бүлийн сайн хань болох

5: Өөрсдийн үйл хэргийг залгамжлуулах

Энэ бол зүүн зүгийн залбирал юм.



259. Өмнө зүг багш ба ахмадыг төлөөлнө.
 Багш, ахмад хүний сургаалыг шавь нь
 мөрдөх ёстой. Багшийн сургаалыг шавь
 хүн гүн хүндэтгэлтэйгээр хүлээж авах
 ёстой. Энэ бол өмнө зүгийн залбирал юм.



260. Баруун зүг бол гэрлэсэн хосуудыг төлөөлнө. Эхнэр нөхөр хоёр харилцан бие биеэ хүндэтгэж хайрлах ёстой. Энэ харилцаа холбоог мөрдөх нь баруун зүгийн залбирал мөн.



261. Хойд зүг хүний нөхрийг төлөөлнө. Найз нөхөд бие биендээ туслаж, дэмжиж байх ёстой. Бүх муу үйлийг зогсоож сайн бүхнийг үйлдэх хэрэгтэй. Энэ үйлдэл бол хойдзүгийн залбирал гэжээ.



262. Доод зүг бол захирагдагсад ба боолын зүг. Боол нарыг эелдэг зөөлөн, энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэлээр халамжлах хэрэгтэй. Эзэн боолын харьцааг эвтэй найрсагаар зохицуул. Энэ бол доод зүгийн залбирал.



263. Дээд зүг бол хувраг зүг юм. Шавь нар багшийнхаа үгийг биелүүлэх, хүндэтгэх ёстой. Мөн багшийн сургаалыг дэлгэрүүлж, бусдад номлох ёстой. Энэ бол дээд зүгийн залбирал юм.



264. Хэрэв хүн эцэг эх, үр хүүхдийн, багш оюутны, эхнэр нөхрийн, найзнөхөд, хамаатан садан, эзэн боолын, лам харын хоорондын харилцааг зөв сахиж мөрдвөл хамгийн зөв залбирал болно гэж Будда айлдав. Энэ айлтгал “Сужатагийн судар” гэж хожим алдаршжээ. Тэжээгчийн судар үүнээс үүссэн.



265. Бурханы арван их шавь нарын дотор Ананда хамгийн залуу, ухаантай, ой сайтай нь болно. Түүнийг олонд алдаршсан онцгой нэгэн гэж цоллодог байлаа. Харамсалтай нь болох болохгүй бүх юм Анандаас гардаг байв.



266. Ананд нэг өдөр тосгонд бадарчлан явтал, худгаас ус авч байгаа залуухан бүсгүйтэй тааралдаж ус гуйж ув. Бүсгүйн өмссөн хувцасыг харвал доодгарлын ядуухан бүсгүй байлаа. Гэвч Анандэнэ бүхнийг мэдсэн ч ер жигшин зэвүүцсэнгүй.



267. Энэ бүсгүйг Матанги гэдэг ба хэдийгээр дордугсааны боловч цэцэг шиг үзэсгэлэнтэй төрсөн ажээ. Анандыг ус гуйхад аяганд нь цэвэр ус дүүргэж өглөө. Энэ үед Матанги Анандын ихэмсэг жавхлантай сайхан царайг сэмхэнээр харж, сэтгэлд нь хоромхон зуур хайр дурлалын үр соёолж гэнэ.



268. Ананда Матангийн үзэсгэлэн гоог анзааралгүй усаа уучихаад, талархал илэрхийлээд яваад өгчээ. Энэ үед Матанги бүсгүйн сүнс сүлд нь зайлчихсан мэт алмайрч Ананд шиг үзэсгэлэнтэй санваартан хэзээ ч үзээгүйгээ мэдрэв.



269. Энэ нэгэн өдрөөс хойш Матанги бүсгүй сэтгэлийн өвчинд нэрвэгдэж өнгө зүс алдаж эцэж турав. Түүний ээж олон дахин шалгаан асуусны эцэст Матанги бүсгүй болсон явдлыг хэлж би заавал Анандын эхнэр болно гэж зүтгэж гэнэ.



270. Ананд бол Бурханы шавь, таван тачаангуй сэтгэлээс ангижирсан хүн, би чамд хэрхэн яаж туслах билээ гэж охиндоо учирлан хэлж гэнэ. Гэвч өдөр өнгөрөх бүр доройтон гундаж буй охиноо өрөвдөн, нууц тарни сурч Анандыг урхидахаар ярилцаж шийдэв.



271. Алив юм гэдэг хяслантай хойно, Матанги бүсгүйг тарни сайн сурч байх тэр үест Будда ба түүний шавь нарыг Прасенжитхаан хотдоо хүрэлцэн ирэхийг урьж, өглөг хишиг хүртээх тухай мэдэгдэж гэнэ. Будда шавь нараа дагуулан хот орж явах үед Ананд тэднээс хоцорч хишиг хүртээх ёслолд оролцож эс чаджээ.



272. Ёслолоос хоцорсон Анандтосгоноор бадарчлан явсаар санаандгүй Матанги бүсгүйн гэрийн дэргэд иржээ. Бүсгүй хүсэн хүлээсэн хүнээ өөрөө хүрээд ирсэнд ихэд баярлан хөөрч, идээ ундаа бэлтгэн зочлохын зэрэгцээ сурсан тарниа уншиж Анандыг шившиж гэнэ.



273. Шившлэг идшидээ үзүүлж, бурханы номонд мэргэжсэн гэлэн Ананд тарнийн хүчинд ховсдуулан, өөрийгөө захирах ямарч тэнхэлгүй болж, орон гаран ухаантай амьтан Матанги бүсгүйг дагаж дотоод өргөөнд нь орж явчив.



274. Анандыг өөрийгөө захирах ямар ч тэнхэлгүй болчихоод, Матанги бүсгүйн урхинд байх тэр агшинд Будда бүхнийг тольдон мэдээд, Прасенжит хаантай даруй салах ёслол үйлдэн, шавь нараа дагуулсаар орон хийдийн зүг яаран буцжээ.



275. Будда хийддээ эргэн ирж завилан суугаад уншлага айлдмагц, түүний тэргүүнээс гэрэл цагарч, цацарсан гэрэл дунд мянган навчит лянхуа цэцгийн сууриндзаларсан амьдбурхан тодорч Матанги бүсгүйн тарнийг эргүүлэн буцааж хүчийг номхотгожээ.




276. Шившлэгийн хүчинд согтсон Анандын сахилаа эвдэх гэж байх тэр мөчидгэрэлтгуяа цацруулсаар нэгэн их гэрэл тэнгэрээс буун ирж Анандба бүсгүйн биен дээр тусахад, тэр хоёр зүүд, зэрэглээн дундаас сэрэх мэт болж, ухаан санаа нь цэлмэв. Ялангуяа сахилаа зөрчих гэж байсан Ананд ихэд гашуудан чимээгүйхэн уйлж байв.



277. Матанги бүсгүй ухаанаа цэлмэсний хойно ихэд гэмшив. Тэр хоёр өөрийн мэдэлгүй хамтдаа Буддагийн өмнө ирж уучилж өршөөхийг хүсэв. Ананд нэн их гэмшиж, толгойгоо өөд татах чадалгүй мэгшин уйлж суулаа.




278. Энэрэнгүй Будда Анандыг нигүүлсэн өршөөж адислаад бясалгал үйлдэж бурханы хутгийг олох тухай ном айлдав.



279. Дараахан Матанги бүсгүй мөн сахил хүртэж, өөрийгөө зөв залж, хичээнгүйлэн зүтгэснээр архад болсон юм.



280. Бярманы бүлгийн ахлагч Сарипутра нэгэн бүлэг бярманьг сэнхрүүлэн бишрүүлж чадаад Буддаг дагах болов. Гэвч зарим нэгэн үл дагагсад Бурханы сургаал өдрөөс өдөрт мандан бадарч буйд атаархан хорсч, Сравасти хотод цугларч сэм хуйвалдан, Буддаг хорлохоор болж Цинка нэрт эмэгтэйг ашиглахаар шийдэв.



281. Нэгэн өглөө Будда шавь нарынхаа хамт Жетавана хийдэд хурал хурж байхад дотор ерөөнөөс Цинка бүсгүй гарч ирээд олны дундуур явж өнгөрөхдөө:

- Би урьд шөнийг хийдэд өнгөрөөв гэж хэлж олныг цочоов.




282. Найман сарын дараа Цинка хүүхэн жирэмсэн мэт том гэдэстэй дахиад л хийдийн хурлын танхимдорж ирлээ. Буддаг ном айлдаж эхлэх үед Цинка бүсгүй олны дундаас гэнэт босч ирээд, бүдүүрч томорсон гэдсээ, мөн Буддаг зааж чи нададболон төрөөгүй хүүхэддээ байр орон олж өг хэмээн хашгирав.



283. Хэсэг хугацаанд хүмүүс мэл гайхаж, хоорондоо шивэр авир гэцгээж эхлэв. Будда огт хөдөлгөөнгүй яг байснаараа л сууж байв. Яг энэ агшинд нэг модон таваг шалан дээр унах чимээ гарав. Жижиг модон таваг Цинкагийн гэдэснээс унасан байжээ. Тэр жирэмсэн болж жүжиглэсэн нь тодорхой болж сандран гүйж одов.



284. Хорт явуулга нь бүтэлгүй болмогц тэрс үзэлт
 бярман нар өөр ов мэх гаргаж, Сундари нэрт
 бүсгүйг өдөр бүр Жетавана хийдэд очуулж
 ном сургаал сонгоод, саргүй бүрхэг, салхитай
 нэгэн шөнө бусдыг хөлслөн бүсгүйн амийг
 хөнөөв.




285. Дараа өдөр тэрс үзэлт бярман нар залуу бүсгүй алга болсон тухай албан яаманд мэдэгдэж, хийдийн орчныг нэгжихийг шаардав. Эцэст нь бүсгүйн цогцсыг хийдийн хаалганы орчмоос олов. Энэ үйл явуулга сүсэгтэн олны дотор шуугиан тарьж, бүсгүйн үхэлтэй хийдийн лам хувраг холбоотой биш бизгэсэн эргэлзээ төрүүлэв.



286. Зарим сүсэгтэн эргэлзэж, итгэл алдарснаас хийдэд ирэгсэдийн тоо эрс цөөрч, хийдэд таагүй байдал үүсэв. Гэвч Будда үнэн үйл бүхнийг ялна гэж тунхаглаад, хүний амь хөнөөнө гэдэг бол хамгийн муухай үйлдэл мөн, муу юмны хариу муу л байна. Хэзээ ч ариун гэгээн байх учиргүй гэж айлдав.




287. Үнэхээр удалгүй алуурчид хоорондоо шан харамжаа хуваах тухай маргаж байгаад баригдав. Жетавана хийдийн лам нарыг буруутгах гэж тэрс үзэлт бярман нар турхирсан болох нь илэрлээ. Бүх гэмтэн зохих ёсоор цээрлэл хүлээв.



288. Тэрс үзэлт бярман нарын хорт үйлдэл сүйрч үнэн нүүр царай нь илэрч Буддагийн шавь нарын нэр хүнд алс холд цуурайтах болж дөрвөн зүг найман зовхисоос шавь орж сахил хүртэх гэсэн хүмүүс борооны үүл мэт хуран цугларсаар байлаа. Энэ нь сүүдэртэй тал нь илрэхгүй бол гэрэлтэй тал нь тодрохгүй гэсэн үнэний нотолгоо болов.



289. Буддагийн үеэл дүү Девадатта нь анх гэрээс гарч сахил хүртсэн долоон хан хүүгийн нэг юм. Хэдийгээр үсээ авахуулж сахил хүртсэн ч түүний хорлонтой мөн чанар ерөөс өөрчлөгдсөнгүй. Тэр хэдийвээр бурханы сургаалыг сурч байсан ч зорилго нь өөр, бусдыг өөртөө татаж нэр хүнд олох явдал байв.



290. Нэг өдөр Девадатта Бурханд бараалхан сургаал айлдахыг хүсчээ. Будда түүнд бурханы шавь гэдэг бол цээр сахих, цээр сахивал тогтооно, тогтоовол оюун ухаан сэргэнэ гэж айлдав.



291. Девадатта Бурханы шавь Анандыг ятгаж, ер бусын ид шид увидас зааж өгөхийг гуйв. Гуйлтыг эс зөвшөөрөх нь эвгүй байсан тул Ананд түүнд увидас зааж эхлэв. Харин Девадатта өөрийн сурсныг буруу зүйлд ашиглаж улмаар найман алуурчин мөнгөөр хөлслөн авч Буддаг хорлохоор зэхэв.



292. Нэгэн удаа Буддаг агуйдаа бясалгал хийж байгааг сонсож мэдээд хөлсний найман алуурчдыг илгээв.



293. Алуурчид түүнийг хөнөөх хүсэл дүүрэн хүрч ирлээ. Гэвч тэд нарны туяа шиг гэрлийн цацраг цацруулж буй Буддаг хараад нүд нь дальдчиж, түүнийг алах хүсэл нь хоромхон зуур унтрав. Тэд бүгд сэлмээ хаяад өвдөг сөхрөн нүглээ наминчлан шавь орохыг хүсчээ.



294. Хар санаатхуйвалдаан сүйрмэгц Девадаттын хорон санаа улам идэвхтэй болов. Нэг удаа Будда Ананд хоёр уулын бэлээр явж байтал Девадатта хамаг хурдаараа гүйж, сурсан жаахан увидасынхаа чадлаар том хадыг нурааж уулын бэл рүү өнхрүүлэв.



295. Өнхрөн ирж буй хадыг харсан Ананда хурдан зайлахаар гүйхэд, Будда огт хөдөлгөөнгүй сүрлэг уул мэт зогсов. Гайхалтай нь хад хагаран Буддагийн хажуугаар эргэлдэн уналаа. Будда огт гэмтсэнгүй.



296. Девадатгагийн хорон муу санаа биелээгүй тул улам хорсож, сурсан жаахан эрдмээ ашиглан төрийн хэрэгт оролцож өөрийн хүчийг зузаатгахыг зорив. Үүний тулд Бимбасара хааны хүү гэнэн залуу, итгэмтгий Ажатасатруг ятгаж хууран өөртөө итгүүлжээ.



297. Девадатта Бурханы суурийг, хан хүү хааны суурийг эзлэх эрмэлзлэлтэй байсан тул санаа ихэд нийлж, хамтран үгсэж үймээн дэгдээж төрийг эргүүлэв.




298. Төр авсан хан хүү эзэн хааныг гянданд хорив. Хаан Буддагийн сургаалд үнэнч тул итгэл алдрахгүй байлаа.



299. Төрийг авсны хойно хан хүү Ажатагатру, Девадаттаг Магадын эзэнт гүрний төрийн зөвлөх болгов. Ийнхүү энэ хоёрын хорон санаа биелж ордны гунигт жүжиг эхлэв.



300. Их хатан Вайдехи шоронгийн хуягийг мэхэлж, хоригдож буй эзэн хааныг хоёр өнжөөд нэг удаа эргэдэг байв. Их хатан эргэх болгондоо хамаг биендээ зөгийн бал ба үзэмний зутан түрхээд эзэн хаанд өгч түүнийг өлсөж үхэх аюулаас гэтэлгэж байлаа.




301. Бимбасара хаан шоронд байхдаа цээрлэх найман зүйлийг хэлж өгч, сахил хүртээхийг бурханаас хүсч залбирч байлаа. Будда увидасын чадалт Маудгальянаг илгээж сахил хүртээсэн ба мөн Пурна бурханыг илгээж ном айлтгуулав.



302. Нэг өдөр шинэ хаан шоронд буй хааны байдлыг хуягаас асуув. Хуяг байдлыг үнэн мөнөөр нь хэлсэнд, шинэ хаан ихэд хорсож, сэлэм далайн хатан ээжээ алахыг завдав.



303. Түүнийг нэг их түшмэл хорьж амийг нь өршөөхийг гуйсанд уурласан хаан хүү эхийгээ ордны хорионд байлга, гадагш гаргаж болохгүй гэж зарлиг буулгав.




304. Их хатан Вайдехи Вултур уулын чигт харж суугаад Буддагаас аврал эрэн залбирч байв. Будда Маудгаляна ба Анандыг илгээв. Тэд хатны хоригдож буй ордонд тэнгэрээс бууж ирэв.



305. Хатны хүсэлтээр ертөнцийг цэвэр ариун сэтгэлээр мэдрэх тухай арван зургаан ажиглах аргын тухай номлов. Энэ бол цэвэр ариун чанарын гурван их судрын нэг цаглашгүй наст бурханы судар юм.



306. Буддагийн хэлж сургасан ёсоор, хатан арван зургаан зарчмыг бясалгаж, тусыг олж Бурханы их хүчээр дээд зэргийн баяр цэнгэлийг эдлэв.



307. Хорон санаат Девадатта зэрлэг заан ашиглаж Буддаг хөнөөхөөр шийдэв. Нэгэн өдөр Будда өөрийн шавь нарын хамт Ражагара хотын ойролцоо бадарчилан явж байх үест, гэнэт нэгэн догшин заан Буддаг чиглэн довтлон ирэв.



308. Зэрлэг заан Бурханд дөхөж ирмэгцээ гэнэт хэвтээд өгөв. Маш номхон болж, Буддагийн өмнө өвдөг сөхрөв. Бурхан дараа нь зэрлэг заандгурван номдорох тухай сургаал айлдахад зааны нүднээс нулимс асгарч байлаа.




309. Деваддагийн хар муу үйл туйлдаа хүрч нүгэл нь нүдээрээ гарч нэг салхитай бороотой шөнө тахал мэт хүнд өвчнийг тэсвэрлэсэнгүй өвдөлтөөс болж хорвоогоос тонилов. Тэр завсаргүй нүгэл үйлдсэн, дуусашгүй тамын орондунажээ. Төгсгөлгүй цагт тоолшгүй олон удаа дахин дахин төрж зовж байх болов.




310. Девадатта нас барсны дараахан өвгөн хаан мөн бие барав. Хан хүү Ажатаватру сэтгэл улам тавгүйтэж, гонсгор байх болжээ. Нэг шөнө түүний зүүдэнд хаан эцэг нь үзэгдэж буруугаа гэмшиж биеэ засч шинэ хүн бол гэж ятгаж байлаа.



311. Шинэ хааны нүгэлтгүйлийн нь хариуирж бүх биеэр нь хортяр гарч маш их зовоон, ямар ч эмч, оточ эмчлэх гээд тусыг эс олов. Ахмад сайд нар түүнийг тайвшруулах гэж хамаг чадлаа баравч тусыг олсонгүй.



312. Ахмад сайд Жива хааны бие чилээрхсэнийг сонсоод эргэж ирэв. Ахмад сайд Живад хан хүү сэтгэлийн зовлонгоо уудлан ярьсанд Жива сайд: Та Буддагаас тусламж эрэх нь зөв болов уу? гэж зөвлөсөнд хажууд нь байсан бусад сайд түшмэлүүд ихэд цочин, хан хүү хилэгнэх биз гэж бодож байтал Ажатасатру хаан баяртайгаар мишээн зөвшөөрч гэнэ.



313. Ажатасатру хаан бараа бологсод, заан хөлөглөсөн сайдуудтайгаа Бурханд ихээхэн өргөл, бэлэг барьж бараалхахаар бэлтгэж байв. Замын хагаст Девадаттагийн хамт Бурханы амь насанд халдахаар хэрхэн хуйвалдаж байсан нь бодогдон зүрхшээж эргэлзлээ.



314. Тэрээр Буддад чин үнэнээсээ нүглээ наминчлахаар очих ёстой, буцах ямар ч гарцгүй, тамд унах болно гэсэн Бимбасара хааны үгийг гэнэт тэнгэрээс сонсов. Энэ үг түүнийг зоригжуулж тэр Жетавана хийдрүү шулуухан чиглэлээ.




315. Энэрэн нигүүлсэнгүй Будда Ажатаватсуу хааныг өршөөн хэлтрүүлэв. Харин хаан Буддагийн өмнө сөхрөн сууж нүгэлээ наминчилж орь дуу тавьж уйлахын зэрэгцээ сахил хүртээж өгөхийг хүсэв. Үүнээс хойш тэрбээр Буддагийн үнэнч шавь, Бурханы сургаалыг хамгаалагч эзэн хаадын нэг болсон юм.



316. Ажатасатрухаан нүглээ наминчилж аврагдсан, Девадатта бие барж тамд очсон, ийн учир амгалан энх цаг ирсэн баймаар, гэвч ертөнц зовлонгийн далайд нэгэнт живчихсэн байсан тул нэгэн үе амгалан байвч дахин өөр гамшиг зовлон учирсаар байлаа.



317. Косала эзэнт улс бол хүчтэй цэрэг морьтой, Энэтхэгийн томоохон улсын нэг юм. Хаан Прасенажит Бурханы шавь болж сахил хүртэхийн өмнө Капилавасту улсын Шагж омгоос эхнэр авчээ. Шагж омгийнхон өөрсдийгөө дээд язгуурын гэж үздэг тул өөрийн хатадын охидоос биш, шивэгчин бүсгүй Маликаг эхнэр болгон өгчээ.



318. Прасенажит хаан Маликаг маш их хайрлав. Тэр түүндхан хүү Видудаваг төрүүлж өглөө. Хан хүү найман настай байхдаа Капилавастуд шинэ баригдсан эрдмийн танхимд тоглож зугаалахаар оржээ. Шагж омгийнхон хан хүүг шивэгчний хан хүү гэж доромжлоод хэрүүл шуугиан болж хөөн гаргасан нь ийнхүү өс хонзонгийн үр цацагдах шалтгаан болжээ.



319. Прасенажит хаан тэнгэрт халимагц хааны титэмийг хан хүү өмсөж Видудавха хаан болов. Тэрээр дээрх нэгэн явдлын өш хонзонг авахаар цэрэг морьдыг хил давуулан хөдөлгөв. Гэмгүй Шагж омгийнхоныг энэ аюулаас аврахаар Будда модны сүүдэр дор сууж Видудавха хааны цэргийг хүлээж байв.



320. Яг хүлээснээр нь Видудавха хаан цэргүүдтэйгээ хүрч ирлээ. Бурханыг хараад тэр мэнд амрыг нь айлдав. Та яагаад энэ газрыг сонгон хувхай модны ёроолд бясалган сууна вэ? гэжээ. Энэ бол маш сайн асуулт байна төрөл садны сүүдэр, бусдын сүүдрээс илүү гэдэг биздээ? хэмээн бурхан хариулжээ.



321. Буддагийн үг хааны сэтгэлийг гүнзгий хөдөлгөжээ. Хаан зарлиг буулгаж цэрэг морьдоо буцааж татав. Нэгэн цагт дүрэлзэн асах гэж байсан дайны гал унтарлаа.



322. Видудавха хаан өш хонзонт сэтгэлээ зогсоож чадсангүй мөн л цэргээ аваад бас нэг тулалдаанд оров. Замдаа дахин Буддатай таарч, цэргээ буцааж татлаа. Энэ явдал гурван удаа давтагдав.



323. Видудавхагийн цэрэг Капилавастуд цөмрөн орж энгийн номхон иргэдийг олноор хөнөөлөө. Увидаст Маудгаляна ер бусын ид шидийн хүчээр Шагж омгийн таван зуун шилдгийн шилдэг хүнийг бадар аягандаа татаж оруулаадбагтаачихав. Гэвч аягаа дараа нь нээхэд бүгд цус болсон байлаа.



324. Видудавха хаан хотод дайран орж гучин мянган цэрэг болон энгийн иргэдийг олзолж тэднийг амьдаар толгойг нь ил гаргаж газарт булаад зэрлэг заанаар дайруулж алахаар зэхэж байв.



325. Маханаман бол Амартодона хааны хүү Буддагийн номын дүү, Видудавха хааны нагац аав юм. Тэрбээр Капилавасту улсын хаан болоод эзэнт гүрнээ мэргэнээр удирдан ард иргэддээ энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэлээр ханддаг байв.



327. Гучин мянган хүн хотыг орхин зугттал
Маханаман уснаас гарч ирээгүй л байлаа.
Видудавха яагаад ингэж удаж байгааг
мэдэхээр өөрийн хүнийг хойноос нь усанд
шумбуулжээ. Гэтэл Маханаман хаан голын
ёроолд үсээ модны үндсэнд сайтар уяад хоёр
гараараа хадтэврэн нөгчсөн байв. Тэр ингэж
эрдэнэт амиа бусдыг аврахын төлөө зольж
чадсан нь энэ юм.



328. Капилавасту эзэнт улсыг эзэлж авсны дараа, хаан Видудавха өөрийн хайртай эхнэрийн хамт ордондоо нойрсож байгаад түймрээс зугтан гарч чадалгүй шатаж, нурам болжээ. Үйлийн үр зайлшгүй юм даа.



329. Нэг өдөр Будда бадар аягаа бариад Сравасти орчмоор бадарчлан явж байтал малын баас зөөгч доод зиндааны Сунита тааралджээ. Бурхан түүнийг зогсохыг хүслээ. Доод төрлөөсөө ичиж агуу сүрлэг Буддагийн өөдөөс харж чадахгүй байв. Тэр эргэж зугтах гэж байгаад сагстайгаа асгаж орхив. Малын баасны үнэр хан хийж Сунита өвдөг дээрээ сөхрөөд өршөөл эрэв.



330. Бурхан түүнийг хуваргын амьдралд дагуулж оруулья, Бурхан хүн болгоныг адил тэгш үздэг юм гэж айлтгав. Эгээ л цэвэр ус хир тоос шороог угаан арилгадагийн адил Сунитагийн сэтгэл догдлон баяртайгаар Бурханы өмнө сөгдөн мөргөөд хувраг болохоор шийдлээ.



331. Буддаг Ражагарад сургаал айлдаж байх үед олон хүүхэд төрүүлсэн Харити гэдэг удган эмэгтэй байв. Төрөлхийн муу зан нь бусдын хүүхдийг өчүүхэн ч хайрладаггүй, хулгайлж иддэг этгээд сонин бузар муухай зантай тул түүнийг чөтгөр эх гэж нэрлэдэг байлаа.




332. Бурхан Харитийг хувирган өөрчлөхийг оролдов. Бурхан түүнийг эзгүйд түүний хайртай хүү Бангалог авчруулахаар Виксүг илгээв. Тэр хүүгээ алдсанаа мэдээд өдөржин шаналав. Зарим хүмүүс Буддагаас аврал эрсэн нь дээр гэж түүнийг ятгав.



333. Будда Харитид хэлсэн нь: Та хүүгээ өөрийн амьдрал адил хайрлаж байна. Энэ дэлхийн бусад хүмүүс ч гэсэн үүнтэй адил гэж мэдэх хэрэгтэй. Та ийм их уй гашуу эдлэхдээ хэн нэгний хүүхдийг хулгайлаад идэж байхдаа эцэг эхийнх нь тухай хэзээ нэгэн цагт та бодож үзсэн үү? гэв.



334. Харити эцэс сүүлдээ нүгэлт үйлийнхээ бурууг ойлгон нүглээ наманчилж, энэ ертөнцийн бүхий л хүүхдийг хамгаалж шинээр амьдрахыг хүсчээ. Тэгэхэднь Будда түүний хайртай хүүг буцааж өгсөн байна. Энэ бол Буддагийн хүнийг өөрчилж сэхээрүүлэх олон аргын нэг байв.



335. Буддагийн хүнийг хүмүүжүүлэх сэхээрүүлэх арга нь алив хүний дур сонирхол, номыг хүлээж авах чадвар дээр тулгуурлаж байв. Тэр хувь хүнийг янзбүрийн цаг хугацаа, орон зайд хүч чадал нь тохируулж төрөл бүрийн арга хэлбэрээр сургаж байсан.

Нэг өдөр морь сургагч Бурханаас ном сонсохоор ирэв. Улмаар зөөлөн, ширүүн, зөөлөн, ширүүн хослосон гурван аргаар морийг сургадаг тухайгаа Буддад тайлбарлан яриу.




336. Будда энэ гурван арга үр дүнгүй болбол чи яах вэ? гэж асуухад “Би түүнийг алахаас өөр ямар ч арга үгүй” гэж морь сургагч хариулжээ. Тэгээд харин “Амьд амьтныг сургахад та ямар арга хэрэглэхсэн бол?” гэж бурханаас асуухад заримдаа чиний аргыг... гэж хариулахад тэрээр ихэд гайхшран яагаад? гэж лавлав.




337. Будда: -Заасан зүйлийг эс сурвал заахаа
больчих хэрэгтэй. Энэ бол алснаас өөрцгүй
шүү дээ гэж хариулсанд морь сургагч
Буддагийн сургаалыг ойлгож улмаар таван
сахил авч малтай ширүүн догшин харьцах,
хамаа бусаар амьтны амь тасалж хөнөөхийг
цээрлэв.




338. Будда эхдээ буян үйлдэхээр Индра тэнгэрийн ордонд морилж ном айлдаж байлаа. Мөн Луугийн ордонд морилж сургаал айлдаж байсан. Тэрбээр ид шид увидаст нэвтэрсэн тул аль хүссэн газраа морилж чаддаг байв. Нэгэнтээ түүнийг эзгүй хойгуур Удаяана хаан Буддаг ихэд биширч санан үгүйлж, улсынхаа хамгийн сайн урчуудыг урин цуглуулж нэг алд орчим өндөр Бурханы хөргийг зандан модоор сийлүүлжээ. Энэ бол дэлхий дээрх бурханы анхны сийлбэр байсан юм.



339. Буддагийн сургаал агууих энэрэн нигүүлслээр дүүрэн байлаа. Түүний шавь нарын дунд нэгэн тэнэг залуу байдаг байжээ. Бусад нь түүнийг ямагт ад үздэг байв. Харин Будда түүнийг бусдын нэгэн адил сургасаар байхын зэрэгцээ Анандад түүнд сайтар туслахыг захидаг байлаа.



340. Анандмаш их цаг хүч заржтэнэг Ксудрантакт тарни уншлага цээжлүүлэхийг хичээх боловч тэрбээр сүүлийнхээ өгүүлбэрийг уншаад түрүүнийхээ өгүүлбэрийг мартчихдаг байв. Ананд энэ байдлыг Буддад чин үнэнээр айлтгасанд, аргагүйн эрхэнд өөрөө зааж хамгийн энгийн дөрвөн мөрт магтаал цээжлүүлэхийг оролдов.



341. Ксудрантак тогтоох гэж маш их чармайлт гаргасан боловч түүний оюуны чадвар дэндүү дор огт цээжлэхгүй байв. Түүнийг үеийнхэн нь ном цээжлэх ямар ч чадваргүй гэж үзэж байхад Будда түүнийг орхилгүй дагуулсаар, зааж сургасаар байв.



342. Түүнд Будда: -Чи хог шүүрдэж шавь нарын хувцасыг цэвэрлэж байхдаа ажлаа хийхийн зэрэгцээ “Би цэвэрлэж, шүүрдэж байна” гэдэг үгийг хэлж тогтоо гэж захиж гэнэ.



343. Эцсийн мөчид тэрбээр дээрх үгийг алдаа мадаггүй цээжлэж чадав. Үүнээс хойш түүний сэтгэлийн хир буртаг арилж гэнэт сэнхэрсэн түүхтэй юм.




344. Хөгжимчин Сронакотивимса баян чинээлэг гэр бүлд төрсөн. Эцэг эх нь түүнийг энхрийлж хайрлаж алган дээрээ бөмбөрүүлж, газарт хөлөөр нь гишгүүлж үзээгүй өсгөжээ. Дараа нь өсгөйд нь бүдүүн хар үс ургасан учир түүнээсээ маш их ичдэг байжээ. Нэг өдөр золоор Бурханы сургаал сонсох боломж олдож сэтгэл гүн хөдлөжээ. Тэр гэрээ орхиж лам болохоор шийдэв. Гэвч эцэг эх нь түүнийг бэрхшээлтэй учирна хэмээн цааргалсаар байлаа.



345. Эцэг эх нь хэдийгээр дургүйцэж байсан ч тэрбээр зориг шулуудан гэрээс гарч чадал мэдэн бясалгал үйлдэв. Гэвч угийн бие сул тул шийдвэрээсээ буцаж хар болдог ч юм билүү гэж бодох болов.



346. Бурхан Сронакотивимсад хандаж хөгжим тоглоход хэрэв чавхдас нь хэт чанга татсан бол тасарна, хэт сул бол ая авиа гарахгүй, бясалгал хөгжимтэй адил, чавхдас хэт чанга бус бас сул бус байх ёстой. Ямар ч юманд яг тохирсон аясаар нь ханд, тэрбээр Бурханы сургаалыг хүлээн авч хичээсээр архад болсон юм.



347. Будда нас ная хүрсэн үедээ Ганга мөрнийг гатлаж Важжи эзэнт улсын Паталипурат хотод ном айлдахаар морилон ирэв. Түүний ном сургаалыг шимтэн сонсохоор олон түмэн хуран цугларч Будда олон муу үйлийг цээрлэх, энэрэх сэтгэлийг дээдлэх, өөрийгөө ариутгах, бусдын төлөө сэтгэл гаргах зэрэг бурханы сургаалын үнэнийг номлов.



348. Тэр цагт Ваджжийн эзэнт улсын хөрш Магадха улс маш хүчтэй, сайн сургуулисан цэрэгтэй байв. Түүний хаан Ажатаватсу их шуналтай, цэргээ илгээж Ваджи улсыг эзлэхийг хүсч байлаа. Тэр Варса нэрт сайдаа номын авшиг хүртэх чуулганд илгээж оролцуулах, Буддад мэндчилгээ дамжуулах, Ваджитад халдаж нутгаа өргөсгөх гэсэн санаагаа мөн хэлж явуулжээ.



349. Будда Анандад: -Тэр жил би Камара хийдэд ном тавихдаа Важжигийн олон иргэдэд “Доройтохгүй байх долоон арга”-ын тухай тайлбарласан билээ. Тэд миний хэлснийг дагаа болов уу? Хэрэв тэр аргыг мөрдсөн бол хүчтнийг дарж, эх нутгаа хамгаалж чадна шүү дээ гэхэд нь Ананд таны номлолыг сонссоны дараа итгэл төрж ёсоор дагасан гэж хариулав.



350. Будда Варса сайдад Важжийн бүх хүн ам “Доройтохгүй долоон арга”-ыг хэрэглэх чадвартай, хөрш орны довтолгоог няцааж чадна. Хэрэв дайн болбол тэд ялна гэж хэлжээ. Варса сайд нутагтаа буцаж очоод өөрийн хаанд Буддагийн үгийг дамжуулсанд Буддагийн буян нигүүлсэнгүй Ажитасатру хаанд нөлөөлж, дайн дэгдээхийг зайлуулав.



351. Вайсали хотод Амрадарика нэрт үзэсгэлэнт бүсгүй амьдардаг байжээ. Тэр маш том олон га газартай, олон зарц шивэгчинтэй ажээ. Нэг өдөр тэр Буддаг хотод ирэхийг мэдээд зарц шивэгчингээ дагуулаад морин тэрэг хөллөөд, Будда болон лам нарт баяр хүргэхээр зорин ирэв.



352. Будда Амрадарикад та залуу үзэсгэлэнтэй маш их эрдэнэс баялагтай, эм хүний чанар бүгдийг эзэмшсэн эелдэг нигүүлсэнгүй зантай авч ямарваа юм мөнх бус гэдгийг ойлгох ёстой. Залуу нас удаан үргэлжлэхгүй, ямар ч хүн эцэстээ өтлөж, өвчилдөг, нас бардаг. Юм бүхэнд гэрэл, сүүдэр гэж буй. Нас өндөр болсон хойноо харамсахааргүйгээр амьдрах хэрэгтэй гэж сургав.



353. Амрадарика Буддагийн сургаалд гэгээрэв. Тэр яаралтай бурханы шавь болж таван сахилыг хүртэв. Тэр Бурхан, түүний шавь нартөргөл барьц өгөхөөр гэртээ урив. Бурхан түүний урилгыг дуртайяа хүлээн авав.




354. Амрадарика буцаж явах замдаа Лисави омгийн тэрэгтэй мөргөлдөв. Амрадарика учирласан нь: -Би их Буддад өглөг буян үйлдэх гэж яаран явсны учир мөргөлдчихлөө? хэмээсэнд Лисави омгийн хөтөч Симха гэгч хөгшин Буддагийн агуу нэрийг сонсоод: -Тэгвэл би Буддад өглөг буян үйлдье гэжээ.



355. Тэр хоёр удтал маргаад хэн нь хэндээ буулт үл хийсэн тул Буддад очицгоов. Будда: -Та нар өнгөц бардам байх хэрэггүй. Би эхлээд Амрадарикагийн очъё дараа Симха танайд очъё гэв.



356. Нэг удаа Маудгаляна буян үйлдэж Ражагари ууланд бясалгал хийж байхдаа нүцгэн даяанчийн тэрс үзэлт гишүүдэд хорлогджээ. Будда, түүний шавь нар энэ эмгэнэлт мэдээг гашуудан сонсов.




357. Маудгалянагийн эзэмшсэн увидасны эрдэм чадал, ер бусын хүч тэрс үзэлтний хорлолыг хариулахад элбэг хүрэлцэнэ гэдгийг Будда сайтар мэдэж байлаа.

Гэвч хүний урьд насны үйлийн үр, заяа тавилан боловсрох үед хүн өөрөө сайн дураар энэ биеэ золиосолдог, дараагийн төрлийн шалтгааныг бүрэлдүүлдэг юм гэж Будда номлов.



358. Будда наян нас хүрсэн тэр өдөр Вайсалийн ойролцоох хулсан ойтой тосгонд явж байхдаа би ном тавиад дөчин есөн жилийг өнгөрөөв. Гурван сарын дараа Кусинагара хотын дэргэдэх, хос сал модны дор нирваан болно гэв. Энэ мэдээг сонссон шавь нар нь цөм эмгэнэн гуниглав.



359. Буддаг удалгүй нирваан болно гэдгийг Шарипутра сонсоод хүрэлцэн ирж би таниас урьтаж нирваан болбол зохино. Эрт өдгөө ёсоор олон хуврагын багш нар шавиасаа өмнө нирваан болдог байсан гэж учирлав.



360. Ананда хүндэт багшаа цугларсан олны өмнөөс үдэж өгөв. Шарипутрагийн үг хатуу, зориг чанга нь олныг урамшуулж, тэр салах ёс үйлдэн одов. Төрсөн нутагтаа эргэж очоод орон гэртээ амгалан байж тарина уншиж, баруун талаараа хэвтээдмөнх нойрссон байна.



361. Буддагийн нирваан болох хугацаа өдрөөс өдөрт ойртсоор шавь нар нь улам их сэтгэл зовсоор байлаа. Нэгэн өдөр би бол мөнх бус, энэ бол байгалийн жам, харин миний сургаал бол мөнх. Үүнийг та нар үргэлжлүүлээрэй хэмээн Будда захив.



362. Ананд Буддагаас дараахи дөрвөн зүйлийг лавлав.

1. Буддагийн дараа хэн ном тавих вэ?
2. Хэрхэн амьдрах вэ?
3. Сахил зөрчигсөдийг яаж номхроох вэ?
4. Ном сургаалаа хэрхэн нэгтгэж хүмүүст хүргэх вэ?




363. Будда хариулсан нь:


1. Сахил бол багш
2. Дөрвөн зүг найман зовхист хаана ч амьдарч болно
3. Муухүмүүст тэвчээртэй хандах хэрэгтэй
4. Бүх сургаалын эхлэл нь сэтгэл. Энэ бол Буддагийн хамгийн сүүлчийн үг буюу “Буддагийн захиас үг” гэж нэрлэгдэх болжээ.




364. Бурханыг нирваан дүрд шилжих гэж байтал Субхада нэртэй зуу гаруй настай нэг өвгөн даяанч Буддаг тэнгэрт халих гэж байна хэмээн сонсоод сургаал сонсохоор ирж гэнэ. Лам нар түүнийг саад болох нь гэж айгаад Буддагийн дэргэд очихыг хориглосон боловч Будда түүнийг хүлээж авахыг зөвшөөрөв.




365. Будда Субхадад хэлсэн нь: Хоосон чанар, мөнх бус, нирваан бол амгаланд хүрэх, энэхүү үнэний шалгуур болсон гурван эрдэнийг бясалгагч хүн танин мэдвэл зохино. Цаашлаад дөрвөн үнэн, найман гишүүнт зөв зам мөр, үйлийн арван хоёр шалтгааныг эзэмшиж ойлговоос ангижирч чадмой. Субхада сахил авч Буддагийн хамгийн сүүлчийн шавь болсон гэдэг.




366. Зуны сарын шинийн арван тавны тэргэл сартай шөнө дунд бэлэг дэмбэрэлтэй өлзий хутаг бүрдсэн хос сал модны дор амьд бус, эцэслэсэн бус амар амгалан нирваан дүрийг үзүүлэв. Тэр хос сал моднийтдээ найм байв. Буддаг нирван болох яг тэр цагт тогоруумэт цав цагаан болж өнгө нь хувирав. Тийм учир хожим тогоруун ой буюу “цант мод” хэмээн нэрлэгдсэн ажгуу.



367. Буддаг нирван дүрдшилжсэний дараа түүний шарилыг алтан авсанд байлгав. Шавь нараа эмгэнэж дуусмагц гурван үнэрт анхилуун галын дөлөөр өөрийгөө чандарлав. Дараа нь чандрыг сувдан үрэл мэт болгов.




368. Буддагийн сувдан үрэл чандрыг анх түрүүнд Маллас гүрэнд хадгалж байлаа. Гэтэл бусад улс гүрний хаад илт дургүйцэн Кусинагара хотод цэрэг морьд оруулж булаалдах болов. Иймийн тулд Ажатаватру хаан маргааныг тасалж чандрыг найман гүрэнд тэнцүү хуваан өгөв. Тэр цагаас хойш гүрэн бүр чандрын суварга босгож нандигнан хадгалах болсон ажгуу.



369

369. Будда бодь модны дор бясалгал үйлдэж гэгээрлийг олсны дараа дөчин есөн жил ном тавьж, гурван зуу илүү судрын сургаал номлолоо айлдсан билээ.



370. Энэтхэгийн Пали хэлээр Буддагийн сургаалыг анх бичиж үлдээснийг Трипитка буюу гурван сав хэмээн ангилан номлож судлаж иржээ. Хожим энэ гурван сав ном Санскрит хэлээр улам өргөжин баяжсан юм. Гурван сав номын нэгдэх нь Монголоор номхотголын аймаг буюу Винайн аймаг, хоёр дахь нь Судрын аймаг, гурав дахь нь Илт номын буюу Абхидхармын аймаг болно.



ТӨГСГӨЛИЙН ҮГ

Энэ номын буянтан тантай хамт бөгөөд энэхүү гайхамшигтай, магад ч үгүй өөрөөр байж байхын аргагүй номын сүүлчийн хуудсыг хаахдаа сэтгэл онож хэлэхийн аргагүй гонсгордуу байна. Гэвч Бурхан Буддагийн агуу суут амьдрал, сургаал номлол их гэгээрлийн хүчээр ямар ч муу муухайг хувьсан өөрчлөгч ид шид таны сэтгэлийг хөдөлгөн, оюун санааг өөрчилсөн гэдэгт итгэнэ.

Ерөөс хэн ч гэлээ ганцхан удаа уншаад номыг хамхих биш амьдралын туршид нээлттэй байх ном гэдэгт итгээрэй.

Сайн сайхан үйлс дэлгэрэх болтугай.

Дуун хөрвүүлэгч бичээч
Маналжавын Шагдарсүрэн
2010.04.13

